



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 08 дугаар сарын 24
№ 32 (1230)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

590.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		2413
591.	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай		2415
592.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		2420
593.	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай		2421

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

594.	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 51	2422
595.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 52	2422
596.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 53	2423
597.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 55	2423
598.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 56	2424



599.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 57	2424
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
600.	Жагсаалт батлах тухай	Дугаар 163	2425
601.	Жагсаалт шинэчлэн батлах тухай	Дугаар 164	2439
602.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 183	2441
603.	Журам батлах тухай	Дугаар 188	2447
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ			
604.	Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 02	2450

Үндэсний		Төрийн мэдээлэл	
7016070	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл
7016071	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл
0701071	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл
6701071	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл
707071	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл
707071	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл
707071	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл
0701071	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл
0701071	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл	Төрийн мэдээлэл

	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ		
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000
1000000	Хувьцаагчид өгөх хөрөнгийн үнэ	1000000	1000000

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 08 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 54¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“54¹ дүгээр зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр /тогтоол/-ээр Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх журам

54¹.1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр /тогтоол/-ээр Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэнэ.

54¹.2.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар зохицуулаагүй асуудлыг энэ хуулийн 5 дугаар бүлэгт заасан хууль хэлэлцэх ерөнхий журмыг баримтлан хэлэлцэнэ.

54¹.3.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүний асуулт асуух хугацаа 5 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй, гишүүний асуултад хариулах хугацаа 5 минутаас илүүгүй, нэмэлт хариулт, тайлбар өгөх хугацаа 1 минутаас илүүгүй, гишүүн үг хэлэх хугацаа 5 минутаас илүүгүй байна.

54¹.4.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл хэлэлцэхэд энэ хуулийн 9.1, 9.3 дахь хэсэг хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлд заасныг баримтлан энэ хуулийг 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 08 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах бүлэг, хэсэг нэмсүгэй:

1/1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг:

“1.4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр /тогтоол/ гарсантай холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, батлахтай холбогдсон харилцааг Монгол Улсын Их Хурал тусгайлсан дэгээр хэлэлцэж болно.”

2/ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:

“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ЭЦСИЙН ШИЙДВЭР /ТОГТООЛ/-ЭЭР МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

18 дугаар зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр /тогтоол/-ээр Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх журам

18.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэг, Жаран долдугаар зүйл, Жаран наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгосон бол хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцүүлэгт бэлтгэж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

18.2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр /тогтоол/-ээр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд энэ хуулийн 3.3 дахь хэсэг, 10 дугаар зүйл, 11.4 дэх хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 40.1 дэх хэсэгт заасныг баримтлахгүй байж болно.

18.3.Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд тухайн Байнгын хороонд харьяалагддаг нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн ирцтэй бол, нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурав /57/-аас доошгүйн ирцтэй бол түүнийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж үзнэ.

18.4.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр хэлэлцүүлгээр шийдвэрлэнэ.

18.5.Нэг дэх хэлэлцүүлгээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр /тогтоол/-ээр хүчингүй болгох Монгол Улсын Үндсэн хуулийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэж, санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

18.6.Нэгдсэн хуралдаан Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар санал хураан шийдвэрлэнэ.

18.7.Нэг саналаар 3 хүртэл удаа санал хурааж болох бөгөөд 2 удаа Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авсан, нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан саналыг дэмжигдсэн санал гэж үзнэ.

18.8.Нэгдсэн хуралдаанаар санал хураалт явуулж дууссаны дараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлнэ.

18.9.Төрийн байгуулалтын байнгын хороо нэгдсэн хуралдаанаар дэмжигдсэн саналыг нэгтгэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болгон эцсийн хувилбарыг бэлтгэн санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

18.10.Нэгдсэн хуралдаанаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурав, түүнээс дээш хувь нь “батлах” санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцож, нийтэд зарлан мэдээлнэ.



18.11.Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгосноос хойш ажлын хоёр өдрийн дотор Монгол Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид биечлэн хүргэж, танилцуулна.

18.12.Монгол Улсын Ерөнхийлөгч танилцсанаас хойш ажлын гурван өдрийн дотор “... оны ... дугаар сарын ...-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн уг эх мөн болой. Монгол Улсын Ерөнхийлөгч ...” гэсэн гарын үсэг зурж, төрийн тамга дарж баталгаажуулан Монгол Улсын Үндсэн хуулийн уг эхийн хамт хадгална.

18.13.Монгол Улсын Ерөнхийлөгчийн нотлон баталгаажуулсан уг эхийг Монгол Улсын Үндсэн хуульд байршуулж, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эхэд тооцно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Зүйл 2-ийн нэмэлт хэсэг

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД БАЙРШУУЛЖ, “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ” ЭМХЭТГЭЛД НИЙТЛЭХ БӨГӨӨД ТҮҮНИЙГ АЛБАН ЁСНЫ ЭХЭД ТООЦНО.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД БАЙРШУУЛЖ, “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ” ЭМХЭТГЭЛД НИЙТЛЭХ БӨГӨӨД ТҮҮНИЙГ АЛБАН ЁСНЫ ЭХЭД ТООЦНО.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД БАЙРШУУЛЖ, “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ” ЭМХЭТГЭЛД НИЙТЛЭХ БӨГӨӨД ТҮҮНИЙГ АЛБАН ЁСНЫ ЭХЭД ТООЦНО.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД БАЙРШУУЛЖ, “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ” ЭМХЭТГЭЛД НИЙТЛЭХ БӨГӨӨД ТҮҮНИЙГ АЛБАН ЁСНЫ ЭХЭД ТООЦНО.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД БАЙРШУУЛЖ, “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ” ЭМХЭТГЭЛД НИЙТЛЭХ БӨГӨӨД ТҮҮНИЙГ АЛБАН ЁСНЫ ЭХЭД ТООЦНО.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД БАЙРШУУЛЖ, “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ” ЭМХЭТГЭЛД НИЙТЛЭХ БӨГӨӨД ТҮҮНИЙГ АЛБАН ЁСНЫ ЭХЭД ТООЦНО.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД БАЙРШУУЛЖ, “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ” ЭМХЭТГЭЛД НИЙТЛЭХ БӨГӨӨД ТҮҮНИЙГ АЛБАН ЁСНЫ ЭХЭД ТООЦНО.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД БАЙРШУУЛЖ, “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ” ЭМХЭТГЭЛД НИЙТЛЭХ БӨГӨӨД ТҮҮНИЙГ АЛБАН ЁСНЫ ЭХЭД ТООЦНО.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД БАЙРШУУЛЖ, “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ” ЭМХЭТГЭЛД НИЙТЛЭХ БӨГӨӨД ТҮҮНИЙГ АЛБАН ЁСНЫ ЭХЭД ТООЦНО.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 08 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын “хууль” гэсний өмнө “Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бусад” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Бусад тусгай зориулалтын
хөрөнгийн тухай хууль

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

Бусад тусгай зориулалтын хөрөнгийн тухай хууль

6 дүгээр зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

7 дүгээр зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Бусад тусгай зориулалтын хөрөнгийн тухай хууль



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 08 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “хууль” гэсний өмнө “Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бусад” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 75 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Түндэвийн Энхмааг Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Саудын Арабын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зоригтын Чинтүшигийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Саудын Арабын Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шижээхүүгийн Одонбаатарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гончигийн Ганболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамбажавын Ганболдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 55

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 80 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Лхагваагийн Оюунцэцэгийг Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 56

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 86 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Ёндонгийн Бямбацэрэнг Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 57

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.1 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 85 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Шүүгчийн албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан Зүмбэрэллхамын Шүрэнчулууныг Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 4 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 163

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.9, 38.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.6, 13.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгслийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН САЙД**

Л.ХАЛТАР

Засгийн газрын 2022 оны 163 дугаар
тогтоолын хавсралт

ГААЛИЙН БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ИРГЭНИЙ АГААРЫН ХӨЛӨГ, ХӨДӨЛГҮҮР БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ДАДЛАГАЖУУР, ТЭДГЭЭРИЙН ЭД АНГИ, БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ, ДЭД УГСРАЛТЫН ХЭСЭГ, СЭЛБЭГ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ХОЛБОГДОХ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	БТКУС-ийн мөрийн код	Барааны нэр
1.	3917.21	Этилений полимерийн хатуу хоолой, гуурс, шланг, тэдгээрийн холбоос
2.	3917.22	Пропилений полимерийн хатуу хоолой, гуурс, шланг, тэдгээрийн холбоос
3.	3917.23	Винилхлоридын полимерийн хатуу хоолой, гуурс, шланг, тэдгээрийн холбоос
4.	3917.29	Бусад хуванцрын хатуу хоолой, гуурс, шланг, тэдгээрийн холбоос



5.	3917.31	Хагаралтын хамгийн бага даралт нь 27.6 мПа байх уян гуурс, хоолой, шланг, тэдгээрийн холбоос
6.	3917.33	Бэхжүүлээгүй, эсхүл өөр материалтай хослуулаагүй уян хоолой, гуурс, шланг, тэдгээрийн холбоос
7.	3917.39	Бэхжүүлсэн, эсхүл өөр материалтай хослуулсан уян хоолой, гуурс, шланг, тэдгээрийн холбоос
8.	3917.40	Хуванцар хоолой, гуурс, шлангны тоноглол
9.	3926.90	Бусад хуванцар эд зүйлс
10.	4008.29	Хатуу хаймраас бусад торлог бус хаймраар хийсэн, хэмжээгээр нь зүсэж хэлбэржүүлсэн бүтээгдэхүүн
11.	4009.12	Бэхжүүлээгүй, эсхүл өөр аргаар бусад материалаар чанаржуулаагүй, хатуу хаймраас бусад хүхэржүүлсэн хаймраар хийсэн, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай хоолой, гуурс, шланг, нэмэлт хэрэгслийн хамт
12.	4009.22	Зөвхөн металлаар бэхжүүлсэн, эсхүл өөр аргаар чанаржуулсан, хатуу хаймраас бусад хүхэржүүлсэн хаймраар хийсэн, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай хоолой, гуурс, шланг, нэмэлт хэрэгслийн хамт
13.	4009.32	Бэхжүүлээгүй, эсхүл өөр аргаар бусад материалаар чанаржуулаагүй, хатуу хаймраас бусад хүхэржүүлсэн хаймраар хийсэн, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай хоолой, гуурс, шланг, нэмэлт хэрэгслийн хамт
14.	4009.42	Бусад материалаар бэхжүүлсэн, эсхүл өөр аргаар чанаржуулсан, хатуу хаймраас бусад хүхэржүүлсэн хаймраар хийсэн, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай хоолой, гуурс, шланг, нэмэлт хэрэгслийн хамт
15.	4011.30	Онгоцны хийлдэг, шинэ хаймар дугуй
16.	4012.13	Онгоцны сэргээсэн, хийлдэг хаймар дугуй
17.	4012.20	Ашиглагдсан хийлдэг хаймар дугуй
18.	4016.10	Хатуу хаймраас бусад торлог хаймраар хийсэн зүйлс
19.	4016.93	Хатуу хаймраас бусад хүхэржүүлсэн хаймраар хийсэн жийргэвч, даравч болон бусад жийрэг
20.	4016.99	Хатуу хаймраас бусад хүхэржүүлсэн хаймраар хийсэн зүйлс
21.	4017.00	Хатуу хаймраар хийсэн хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай хоолой, гуурс, шланг, нэмэлт хэрэгслийн хамт
22.	4504.90	Шахмал үйсээр хийсэн жийргэвч, даравч болон бусад жийрэг
23.	4823.90	Цаасан, эсхүл картоноор хийсэн жийргэвч, даравч болон бусад жийрэг
24.	6812.80	Хувцас, хувцасны зүйлс, гутал болон малгай, цаас, зузаан картон болон эсгий, эсхүл шөрмөсөн чулуун мяндсыг нягтруулан шахаж хийсэн хуудсан, эсхүл хуйлмал материалаас бусад крокидолитоор хийсэн зүйлс
25.	6812.99	Шөрмөсөн чулуугаар хийсэн бусад зүйлс



26.	6813.20	Шөрмөсөн чулуу агуулсан үрэлтийн материалаар хийсэн, угсраагүй тоормосны жийргэвч, зөөллүүр болон залгах механизм, эсхүл эдгээртэй төстэй зориулалттай зүйлс
27.	6813.81	Шөрмөсөн чулуу агуулаагүй үрэлтийн материалаар хийсэн, угсраагүй тоормосны жийргэвч болон зөөллүүр
28.	6813.89	Шөрмөсөн чулуу агуулаагүй үрэлтийн материалаар хийсэн, залгах механизм, эсхүл эдгээртэй төстэй зориулалттай зүйлстэй угсраагүй зүйлс
29.	7007.21	Аюулгүйн үелүүлсэн салхины шил
30.	7304.31	Төмөр (ширэмнээс бусад), эсхүл чанаржуулаагүй гангаар хийсэн, хүйтнээр сунгасан, эсхүл хүйтнээр цувисан (хүйтнээр шахсан), дугуй хөндлөн огтлолтой, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй, ширээсгүй нарийн, бүдүүн хоолой
31.	7304.39	Төмөр (ширэмнээс бусад), эсхүл чанаржуулаагүй гангаар хийсэн, хүйтнээр сунгасан, эсхүл хүйтнээр цувисан (хүйтнээр шахсан)-аас бусад, дугуй хөндлөн огтлолтой, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй ширээсгүй нарийн, бүдүүн хоолой
32.	7304.41	Зэвэрдэггүй гангаар хийсэн, хүйтнээр сунгасан, эсхүл хүйтнээр цувисан (хүйтнээр шахсан), дугуй хөндлөн огтлолтой, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй ширээсгүй нарийн, бүдүүн хоолой
33.	7304.49	Зэвэрдэггүй гангаар хийсэн, хүйтнээр сунгасан, эсхүл хүйтнээр цувисан (хүйтнээр шахсан)-аас бусад, дугуй хөндлөн огтлолтой, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй ширээсгүй нарийн, бүдүүн хоолой
34.	7304.51	Зэвэрдэггүй гангаас бусад чанаржуулсан гангаар хийсэн, хүйтнээр сунгасан, эсхүл хүйтнээр цувисан (хүйтнээр шахсан), дугуй хөндлөн огтлолтой, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй ширээсгүй нарийн, бүдүүн хоолой
35.	7304.59	Зэвэрдэггүй гангаас бусад чанаржуулсан гангаар хийсэн, хүйтнээр сунгасан, эсхүл хүйтнээр цувисан (хүйтнээр шахсан)-аас бусад, дугуй хөндлөн огтлолтой, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй ширээсгүй нарийн, бүдүүн хоолой
36.	7304.90	Төмөр (ширэмнээс бусад), эсхүл гангаар хийсэн, дугуй хөндлөн огтлолтойгоос бусад, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй ширээсгүй нарийн, бүдүүн хоолой
37.	7306.30	Төмөр, эсхүл чанаржуулаагүй гангаар хийсэн, дугуй хөндлөн огтлолтой, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй, гагнамал нарийн, бүдүүн хоолой
38.	7306.40	Зэвэрдэггүй гангаар хийсэн, дугуй хөндлөн огтлолтой, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй гагнамал нарийн, бүдүүн хоолой



39.	7306.50	Зэвэрдэггүй гангаас бусад чанаржуулсан гангаар хийсэн, дугуй хөндлөн огтлолтой, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй гагнамал нарийн, бүдүүн хоолой
40.	7306.61	Төмөр, эсхүл гангаар хийсэн, квадрат, эсхүл тэгш өнцөгт хэлбэрийн хөндлөн огтлолтой, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй гагнамал нарийн, бүдүүн хоолой
41.	7306.69	Төмөр, эсхүл гангаар хийсэн, дугуй биш бусад хөндлөн огтлолтой, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй гагнамал нарийн, бүдүүн хоолой
42.	7312.10	Цахилгаан тусгаарлагчгүй, төмөр, эсхүл гангаар хийсэн, нэмэлт хэрэгсэлтэй томсон утас, олс, кабель
43.	7312.90	Цахилгаан тусгаарлагчгүй, төмөр, эсхүл гангаар хийсэн, нэмэлт хэрэгсэлтэй, сүлжсэн тууз, татлага болон тэдгээртэй төстэй зүйлс
44.	7322.90	Цахилгаан хөдөлгүүрээс эргэлт авч ажиллах сэнс, эсхүл үлээгчээр тоноглогдсон, төмөр, эсхүл гангаар хийсэн, цахилгаанаар ажилладаггүй агаар халаагч, халуун агаар хуваарилагч (эд анги орохгүй)
45.	7324.10	Зэвэрдэггүй гангаар хийсэн тосгуур болон угаагуур
46.	7324.90	Төмөр эсвэл гангаар хийсэн, сантехникийн зориулалттай бусад зүйлс
47.	7326.20	Төмөр эсвэл ган утсаар хийсэн зүйлс
48.	7413.00	Цахилгаан тусгаарлагчгүй, нэмэлт хэрэгсэлтэй, мушгин эрчилсэн зэс утас, кабель, сүлжмэл тууз болон эдгээртэй төстэй зүйлс
49.	7608.10	Хольцгүй хөнгөн цагаанаар хийсэн, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй нарийн, бүдүүн хоолой
50.	7608.20	Хөнгөн цагааны хайлшаар хийсэн, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй нарийн, бүдүүн хоолой
51.	8108.90	Титанаар хийсэн, хий, эсхүл шингэн дамжуулах зориулалттай, нэмэлт хэрэгсэлтэй нарийн, бүдүүн хоолой
52.	8302.10	Үндсэн металлаар хийсэн нугас
53.	8302.20	Үндсэн металлаар хийсэн бэхэлгээний хэрэгсэлтэй, өнхрүүлгэн жижиг дугуй
54.	8302.42	Үндсэн металлаар хийсэн, тавилгын зориулалттай тоног, бэхэлгээний хэрэгсэл болон тэдгээртэй төстэй зүйлс
55.	8302.49	Үндсэн металлаар хийсэн, бусад тоног, бэхэлгээний хэрэгсэл болон тэдгээртэй төстэй зүйлс
56.	8302.60	Үндсэн металлаар хийсэн хаалганы автомат хаагч
57.	8307.10	Төмөр, эсхүл гангаар хийсэн, тоног хэрэгсэлтэй уян хоолой
58.	8307.90	Төмөр, эсхүл гангаас бусад үндсэн металлаар хийсэн, тоног хэрэгсэлтэй уян хоолой



59.	8407.10	Агаарын хөлгийн дотоод шаталтын оч-асаагуурт, түлхэлтэт, эсхүл ротацит бүлүүрэн хөдөлгүүр
60.	8408.90	Агаарын хөлгийн дотоод шаталтын дөл-асаагуурт бүлүүрэн хөдөлгүүр (дизель, эсхүл хагас дизель хөдөлгүүр)
61.	8409.10	8407.10.00, эсхүл 8408.90.00-д дурдсан агаарын хөлгийн хөдөлгүүрүүдэд дагнан болон зонхилон хэрэглэгддэг эд анги
62.	8411.11	Түлхэх хүч нь 25 кН-оос ихгүй турбо тийрэлтэт хөдөлгүүр
63.	8411.12	Түлхэх хүч нь 25 кН-оос их турбо тийрэлтэт хөдөлгүүр
64.	8411.21	1100 кВт-аас ихгүй хүчин чадалтай турбо сэнст хөдөлгүүр
65.	8411.22	1100 кВт-аас их хүчин чадалтай турбо сэнст хөдөлгүүр
66.	8411.81	5000 кВт-аас ихгүй хүчин чадалтай турбо тийрэлтэт болон турбо сэнст хөдөлгүүрээс бусад хийн турбин
67.	8411.82	5000 кВт-аас их хүчин чадалтай турбо тийрэлтэт болон турбо сэнст хөдөлгүүрээс бусад хийн турбин
68.	8411.91	Турбо тийрэлтэт, эсхүл турбо сэнст хөдөлгүүрийн эд анги
69.	8411.99	Турбо тийрэлтэт болон турбо сэнст хөдөлгүүрээс бусад хийн турбины эд анги
70.	8412.10	Турбо тийрэлтэт хөдөлгүүрээс бусад тийрэлтэт хөдөлгүүр
71.	8412.21	Шулуун хөдөлгөөний (цилиндр) усан хөдөлгүүр болон мотор
72.	8412.29	Шулуун биш хөдөлгөөний усан хөдөлгүүр болон мотор
73.	8412.31	Шулуун хөдөлгөөний (цилиндр) хийн шахуургат хөдөлгүүр болон мотор
74.	8412.39	Шулуун биш хөдөлгөөний хийн шахуургат хөдөлгүүр болон мотор
75.	8412.80	Тийрэлтэт, усан, эсхүл хийн шахуургат хөдөлгүүр, мотороос бусад цахилгаан биш хөдөлгүүр болон мотор
76.	8412.90	Цахилгаан биш тийрэлтэт, усан, эсхүл хийн шахуургат хөдөлгүүр болон моторын эд анги
77.	8413.19	Хэмжих төхөөрөмжтэй угсрагдсан, эсхүл угсрагдаж болохоор зохион бүтээгдсэн шингэний насос
78.	8413.20	Хэмжих төхөөрөмжтэй угсрагдаагүй, эсхүл угсрагдаж болохоор зохион бүтээгдээгүй шингэний гар насос
79.	8413.30	Дотоод шаталтын бүлүүрэн хөдөлгүүрийн зориулалттай, шатахуун, тослох материал, эсхүл хөргөгч шингэний насос
80.	8413.50	8413.19.00, 8413.20.00, 8413.30.00-д дурдсанаас бусад түлхэлтэт механизмтай шингэний насос
81.	8413.60	8413.19.00, 8413.20.00, 8413.30.00-д дурдсанаас бусад эргэлтэт механизмтай шингэний насос
82.	8413.70	8413.19.00, 8413.20.00, 8413.30.00-д дурдсанаас бусад төвөөс зугтагч үйлдлийн шингэний насос
83.	8413.81	8413.19.00, 8413.20.00, 8413.30.00, 8413.50.00, 8413.60.00, 8413.70.00-д дурдсанаас бусад шингэний насос
84.	8413.91	Шингэний насосын эд анги
85.	8414.10	Вакуум насос
86.	8414.20	Агаарын гар, эсхүл хөл ажиллагаатай насос



87.	8414.30	Хөргөх төхөөрөмжийн зориулалттай агаарын, эсхүл хийн компрессор
88.	8414.51	Ширээ, шал, хана, цонх, тааз, эсхүл дээвэрт байрлуулах зориулалттай, 125 Вт-аас ихгүй хүчин чадалтай цахилгаан хөдөлгүүрт салхилуур
89.	8414.59	8414.51-д зааснаас бусад салхилуур
90.	8414.80	Агаарын бусад насос, агаарын, эсхүл хийн компрессор
91.	8414.90	Агаарын, эсхүл вакуум насос, агаарын, эсхүл хийн компрессор болон салхилуурын эд анги
92.	8415.81	Хөргөх төхөөрөмжтэй, агаарын хүйтэн/дулаан урсгалын эргэлтийг тохируулах хавхлагатай (тохируулгатай дулааны насос) моторт салхилууртай, агаарын температур, чийгийг өөрчлөх элементтэй агааржуулагч төхөөрөмж (чийгийг тусад нь тохируулдаггүй машин орно)
93.	8415.82	Хөргөх төхөөрөмжтэй, гэхдээ агаарын хүйтэн/дулаан урсгалын эргэлтийг тохируулах хавхлагагүй моторт салхилууртай, агаарын температур, чийгийг өөрчлөх элементтэй агааржуулагч төхөөрөмж (чийгийг тусад нь тохируулдаггүй машин орно)
94.	8415.83	Хөргөх төхөөрөмжгүй, моторт салхилууртай, агаарын температур, чийгийг өөрчлөх элементтэй агааржуулагч төхөөрөмж (чийгийг тусад нь тохируулдаггүй машин орно)
95.	8415.90	8415.81.00, 8415.82.00, 8415.83.00-д дурдсан агааржуулагч төхөөрөмжийн эд анги
96.	8418.10	Тусдаа гадна хаалгатай эсвэл шургуулгатай, эсхүл эдгээрийг хослуулсан хөргөөгч-хөлдөөгч
97.	8418.30	800 л-ээс ихгүй багтаамжтай, хайрцаг маягийн хөлдөөгч
98.	8418.40	900 л-ээс ихгүй багтаамжтай, босоо байрлалтай хөлдөөгч
99.	8418.61	Дулаан солилцогч конденсатортой, шахуургат хөргөх төхөөрөмж
100.	8418.69	8418.10.00, 8418.30.00, 8418.40.00, 8418.61.00-д дурдсан хөргөх, хөлдөөх төхөөрөмж, эсхүл ахуйн хөргөгч, хөлдөөгчөөс бусад хөргөх, хөлдөөх төхөөрөмж
101.	8419.50	Дулаан солилцооны агрегат
102.	8419.81	Халуун ундаа бэлтгэх, эсхүл хүнсний зүйлс бэлтгэх, халаах зориулалттай аппарат
103.	8419.90	8419.50.00-д дурдсан дулаан солилцооны агрегатын эд анги
104.	8421.19	Центрифуг
105.	8421.21	Ус шүүх, цэвэршүүлэх машин, тоног төхөөрөмж
106.	8421.23	Дотоод шаталтын хөдөлгүүрийн тос, бензин шүүгч
107.	8421.29	8421.23.00-д дурдсан, эсхүл ус, ундаанаас бусад шингэнийг шүүх, цэвэрлэх машин, төхөөрөмж
108.	8421.31	Дотоод шаталтын хөдөлгүүрийн агаарын шүүлтүүр

109.	8421.39	Дотоод шаталтын хөдөлгүүрийн агаарын шүүлтүүрээс бусад хий шүүх, цэвэрлэх машин, төхөөрөмж
110.	8424.10	Цэнэглэсэн, эсхүл цэнэглээгүй гал унтраагч
111.	8425.11	Чингэлэгт өргүүрээс бусад цахилгаан мотортой дамарт өргүүр болон бусад өргүүр
112.	8425.19	Чингэлэгт өргүүрээс бусад цахилгаан моторгүй дамарт өргүүр болон бусад өргүүр
113.	8425.31	Цахилгаан мотортой эргүүр, хөшүүрэгт эргүүр
114.	8425.39	Цахилгаан мотортойгоос бусад эргүүр, хөшүүрэгт эргүүр
115.	8425.42	Шингэнээр ажилладаг домкрат
116.	8425.49	Шингэнээр ажилладгаас бусад домкрат
117.	8426.99	Бусад кран
118.	8428.10	Лифт болон чингэлэгт өргүүр
119.	8428.20	Хийн шахуургат элеватор болон конвейер
120.	8428.33	Бараа материалыг зөөх тасралтгүй ажиллагаатай туузан элеватор болон конвейер
121.	8428.39	Бараа материалыг зөөх тасралтгүй ажиллагаатай туузангаас бусад элеватор болон конвейер
122.	8428.90	Өргөх, зөөх, ачих, буулгах бусад машин
123.	8443.31	Өгөгдлийг автоматаар боловсруулах машин, эсхүл сүлжээнд холбогдон ажилладаг факс дамжуулах, хэвлэх, эсхүл хувилах хавсарсан үйлдэл гүйцэтгэдэг машин
124.		Өгөгдлийг автоматаар боловсруулах машин, эсхүл сүлжээнд холбогдон ажилладаг, факс дамжуулахаас бусад хоёр, эсхүл түүнээс дээш үйлдлийг гүйцэтгэдэг машин
125.	8443.32	Зүйл 84.42-ын хавтан, цилиндр (бул) болон хэвлэлийн бусад хэрэглэгдэхүүний тусламжтайгаар хэвлэх зориулалттайгаас бусад өгөгдлийг автоматаар боловсруулах машин, эсхүл сүлжээнд холбогдон ажиллах боломжтой матрицын принтер
126.		Зүйл 84.42-ын хавтан, цилиндр (бул) болон хэвлэлийн бусад хэрэглэгдэхүүний тусламжтайгаар хэвлэх зориулалттайгаас бусад өгөгдлийг автоматаар боловсруулах машин, эсхүл сүлжээнд холбогдон ажиллах боломжтой лазерийн принтер
127.	8471.41	Дор хаяж боловсруулах нэг төв блок, оролтын нэг хэсэг, гаралтын нэг хэсгийг нэг корпуст угсарсан буюу угсраагүй, өгөгдлийг автоматаар боловсруулах машин
128.	8471.49	8471.41.00-д зааснаас бусад систем хэлбэрээр нийлүүлсэн өгөгдлийг автоматаар боловсруулах машин
129.	8471.50	8471.41.00, 8471.49.00-д зааснаас бусад боловсруулах блок (санах байгууламж, оролтын хэсэг, гаралтын хэсгээс нэгийг, эсхүл хоёрыг корпустaa агуулсан буюу агуулаагүй)
130.	8471.60	Корпустaa санах байгууламж агуулсан, эсхүл агуулаагүй оролтын хэсэг, эсхүл гаралтын хэсэг



131.	8471.70	Санах байгууламж
132.	8479.89	84 дүгээр бүлгийн бусад газар заагдаагүй тусгай зориулалтын машин, тоног төхөөрөмж: цахилгаан биш starter мотор, цахилгаан биш сэнсний тохируулагч, цахилгаан биш серво-механизм, цахилгаан биш салхины шил арчигч, шингэн хийн аккумулятор, турбо тийрэлтэт, турбо сэнст, эсхүл бусад хийн турбины шахуургат starter, агаарын хөлөгт тусгайлан зохион бүтээсэн ариун цэврийн өрөөний хэрэгсэл, түлхэх хүчний эсрэг хүчийг идэвхжүүлэгч, агаар чийгшүүлэгч, эсхүл агаар хуурайшуулагч
133.	8479.90	8479.89.00-д дурдсан машин, механик хэрэгслийн эд анги
134.	8483.10	Дамжуулгын гол (нударган болон тахир гол орно)
135.	8483.30	Үрлэн, эсхүл өнхрүүлгэн холхивчгүй байгаа холхивчийн гэр, холхивчийн мөлхөвч
136.	8483.40	Шүдэт араа, гинжит араа болон дамжуулгын салангид бусад элементээс бусад араат тэнхлэг болон араат дамжуулагч, үрэл, эсхүл өнхрүүлэгт мушгиа гол, хурдны хайрцаг ба хурд өөрчлөгч бусад хэсэг (эргэлтийн давтамжийг хувиргах конвертер орно)
137.	8483.50	Эрчлүүр болон хүрд (хүрдэт блок орно)
138.	8483.60	Углуурган болон тахир холбоос (универсал холбоос орно)
139.	8483.90	Шүдэт араа, гинжит араа болон дамжуулгын салангид бусад элемент; 8483.10.00, 8483.30.00, 8483.40.00, 8483.50.00, 8483.60.00-д дурдсан зүйлсийн эд анги
140.	8484.10	Металл хуудсыг өөр материалтай хослуулан, эсхүл металлыг хоёр буюу түүнээс дээш үеэр давхарлан хийсэн жийрэг болон түүнтэй төстэй холбоос
141.	8484.90	Уут сав, хайрцаг, эсхүл адил төстэй савлагаатай, янз бүрийн жийрэг, түүнтэй төстэй холбоосуудаас бүрдсэн иж бүрдэл буюу цуглуулга
142.	8501.20	735 Вт-аас их боловч 150 кВт-аас ихгүй хүчин чадалтай, хувьсах/тогтмол гүйдлийн универсал хөдөлгүүр
143.	8501.31	735 Вт-аас их боловч 750 Вт-аас ихгүй хүчин чадалтай, тогтмол гүйдлийн цахилгаан хөдөлгүүр, 750 Вт-аас ихгүй хүчин чадалтай тогтмол гүйдлийн цахилгаан генератор
144.	8501.32	750 Вт-аас их боловч 75 кВт-аас ихгүй хүчин чадалтай тогтмол гүйдлийн цахилгаан хөдөлгүүр болон тогтмол гүйдлийн цахилгаан генератор
145.	8501.33	8501.20.00-д дурдсанаас бусад, 75 кВт-аас их боловч 150 кВт-аас ихгүй хүчин чадалтай тогтмол гүйдлийн цахилгаан хөдөлгүүр, 75 кВт-аас их боловч 375 кВт-аас ихгүй хүчин чадалтай тогтмол гүйдлийн цахилгаан генератор
146.	8501.34	375 кВт-аас их хүчин чадалтай тогтмол гүйдлийн цахилгаан генератор



147.	8501.40	8501.20.00-д дурдсанаас бусад, 735 Вт-аас их боловч 150 кВт-аас ихгүй хүчин чадалтай, нэг фазын хувьсах гүйдлийн цахилгаан хөдөлгүүр
148.	8501.51	8501.20.00-д дурдсанаас бусад, 735 Вт-аас их боловч 750 Вт-аас ихгүй хүчин чадалтай, олон фазын хувьсах гүйдлийн цахилгаан хөдөлгүүр
149.	8501.52	8501.20.00-д дурдсанаас бусад, 750 Вт-аас их боловч 75 кВт-аас ихгүй хүчин чадалтай, олон фазын хувьсах гүйдлийн цахилгаан хөдөлгүүр
150.	8501.53	8501.20.00-д дурдсанаас бусад, 75 кВт-аас их боловч 150 кВт-аас ихгүй хүчин чадалтай, олон фазын хувьсах гүйдлийн цахилгаан хөдөлгүүр
151.	8501.61	75 кВА-аас ихгүй хүчин чадалтай, хувьсах гүйдлийн цахилгаан генератор (синхронон генератор)
152.	8501.62	75 кВА-аас их боловч 375 кВА-аас ихгүй хүчин чадалтай, хувьсах гүйдлийн цахилгаан генератор (синхронон генератор)
153.	8501.63	375 кВА-аас их боловч 750 кВА-аас ихгүй хүчин чадалтай, хувьсах гүйдлийн цахилгаан генератор (синхронон генератор)
154.	8502.11	75 кВА-аас ихгүй хүчин чадалтай, дөл-асаагуурт дотоод шаталтын бүлүүрэн хөдөлгүүр (дизель, эсхүл хагас дизель хөдөлгүүр) бүхий генераторын төхөөрөмж
155.	8502.12	75 кВА-аас их боловч 375 кВА-аас ихгүй хүчин чадалтай, дөл-асаагуурт дотоод шаталтын бүлүүрэн хөдөлгүүр (дизель, эсхүл хагас дизель хөдөлгүүр) бүхий генераторын төхөөрөмж
156.	8502.13	375 кВА-аас их хүчин чадалтай, дөл-асаагуурт дотоод шаталтын бүлүүрэн хөдөлгүүр (дизель, эсхүл хагас дизель хөдөлгүүр) бүхий генераторын төхөөрөмж
157.	8502.20	Оч-асаагуурт дотоод шаталтын бүлүүрэн хөдөлгүүр бүхий генераторын төхөөрөмж
158.	8502.31	Салхины хүчээр ажиллах генераторын төхөөрөмж
159.	8502.39	8502.31.00-д дурдсанаас бусад генераторын төхөөрөмж
160.	8502.40	Роторт цахилгаан хувиргагч
161.	8504.10	Хийн ламп, эсхүл хоолойн балласт эсэргүүцэл
162.	8504.31	Шингэн дүүргэгчтэй диэлектрик трансформатораас бусад 1 кВА-аас ихгүй чадалтай цахилгаан трансформатор
163.	8504.32	Шингэн дүүргэгчтэй диэлектрик трансформатораас бусад 16 кВА-аас их боловч 500 кВА-аас ихгүй чадалтай цахилгаан трансформатор
164.	8504.33	Шингэн дүүргэгчтэй диэлектрик трансформатораас бусад 1 кВА-аас их боловч 16 кВА-аас ихгүй чадалтай цахилгаан трансформатор
165.	8504.40	Цахилгаан статик хувиргагч



166.	8504.50	Хийн ламп, эсхүл хоолойн балласт эсэргүүцлээс бусад цахилгаан индуктор
167.	8507.10	Бүлүүрэн хөдөлгүүрийг асаахад ашиглагддаг хар тугалга-хүчлийн цахилгаан аккумулятор
168.	8507.20	Хар тугалга-хүчлийн бусад цахилгаан аккумулятор
169.	8507.30	Никель-кадмийн цахилгаан аккумулятор
170.	8507.40	Никель-төмрийн цахилгаан аккумулятор
171.	8507.80	Бусад цахилгаан аккумулятор
172.	8507.90	Цахилгаан аккумуляторын эд анги
173.	8511.10	Оч хаягч
174.	8511.20	Асаах соронз, соронзон динам, соронзон ээрцэг дугуй
175.	8511.30	Хуваарилагч, асаах ороомог
176.	8511.40	Цахилгаан стартер мотор болон давхар зориулалттай стартер-генератор
177.	8511.50	Оч-асаагуурт, эсхүл дөл-асаагуурт дотоод шаталтын хөдөлгүүртэй хамт ашиглагддаг цахилгаан бусад генератор
178.	8511.80	Оч-асаагуурт, эсхүл дөл-асаагуурт дотоод шаталтын хөдөлгүүртэй хамт ашиглагддаг цахилгаан очлуур эсвэл асаах төхөөрөмж болон дээрх хөдөлгүүрүүдтэй хамт хэрэглэгддэг таслах хэрэгсэл
179.	8516.80	Мөстөлтийн эсрэг, эсхүл мөс хайлуулагчид ашигладаг зөвхөн энгийн тусгаарлагч бүрээс болон цахилгаан холболттой угсрагдсан цахилгаан халаалтын эсэргүүцэл
180.	8517.14	Үүрэн сүлжээ, эсхүл утасгүй бусад сүлжээний зориулалтын бусад телефон
181.	8517.61	Радио-телеграф, эсхүл радио-телефоны суурин станц
182.	8517.62	8517.61.00-д дурдсанаас бусад радио-телеграф, эсхүл радио-телефоны хүлээн авах, дамжуулах аппарат
183.	8517.69	8517.61.00, 8517.62.40-д дурдсанаас бусад радио-телеграф, эсхүл радио-телефоны зориулалттай аппарат
184.	8517.70	Радио-телеграф, эсхүл радио-телефон аппаратын антенн болон тусгалын антенн
185.	8518.10	Микрофон, түүний суурь
186.	8518.21	Гэртэй дан чанга яригч
187.	8518.22	Нэг гэртэй олон чанга яригч
188.	8518.29	Гэргүй чанга яригч
189.	8518.30	Микрофонтой хосолмол, эсхүл хосолмол биш толгойн чихэвч болон жижиг чихэвч, микрофон болон нэг, эсхүл түүнээс дээш тооны чанга яригчаас бүрдсэн иж бүрдэл
190.	8518.40	Авиа давтамжийн цахилгаан өсгөгч
191.	8518.50	Дууны цахилгаан өсгөгчийн иж бүрдэл

192.	8519.81	Соронзон, оптик, эсхүл хагас дамжуулагч хэрэгсэл хэрэглэдэг дуу бичих аппарат (дуу сэргээх аппаратгүй)
193.	8519.89	Соронзон, оптик, эсхүл хагас дамжуулагч хэрэгсэл хэрэглэдэггүй дуу бичих аппарат (дуу сэргээх аппаратгүй)
194.	8521.10	Соронзон хальстай, дүрс бичих, эсхүл сэргээх аппарат (видео тюнертэй, эсхүл тюнергүй)
195.	8522.90	8519.81.00-д дурдсан соронзон, оптик, эсхүл хагас дамжуулагч хэрэгсэл хэрэглэдэг дуу бичих аппарат (дуу сэргээх аппаратгүй) болон бусад дуу бичих аппарат (дуу сэргээх аппаратгүй)-ын хоёр, эсхүл түүнээс дээш эд ангийг холбосон, эсхүл угсарсан багц, дэд багц
196.	8526.10	Радарын аппарат (Радиолокаторын аппарат)
197.	8526.91	Радионавигацийн тусламжийн аппарат
198.	8526.92	Радиоогийн алсын удирдлагын аппарат
199.	8528.42	Зүйл 84.71-д заасан өгөгдлийг автоматаар боловсруулах системд дагнан, эсхүл зонхилон хэрэглэгддэг электрон цацрагт хоолой бүхий монитор
200.	8528.52	Зүйл 84.71-д заасан өгөгдлийг автоматаар боловсруулах системд дагнан, эсхүл зонхилон хэрэглэгддэг бусад монитор
201.	8528.62	Зүйл 84.71-д заасан өгөгдлийг автоматаар боловсруулах системд дагнан, эсхүл зонхилон хэрэглэгддэг проектор
202.	8529.10	Зүйл 85.26-д заасан аппаратуудад дагнан, эсхүл зонхилон хэрэглэгддэг бүх төрлийн антенн, тусгалын антенн
203.	8529.90	Зүйл 85.26-д заасан аппаратын хоёр, эсхүл түүнээс дээш эд ангийг холбосон, эсхүл угсарсан багц, дэд багц
204.	8531.10	Хулгайн, эсхүл галын аюулын дохиолол болон тэдгээртэй төстэй дохиоллын төхөөрөмж
205.	8531.20	Шингэн кристалл (LCD), эсхүл гэрэл цацруулагч диод (LED) угсрагдсан гэрлэн самбар
206.	8531.80	8531.10.00, 8531.20.00-д дурдсанаас бусад дуут болон гэрлэн дохиоллын цахилгаан төхөөрөмж
207.	8536.70	Шилэн мяндасны, шилэн мяндсан багцын, шилэн кабелийн хуванцар холбогч
208.	8539.10	Бин битүү цацрагт чийдэн
209.	8543.70	Нислэгийн бичлэг хийх хэрэгсэл, цахилгаан синхронизатор болон хувьсгуур, цахилгаан эсэргүүцэл бүхий цан хайлуулагч, цанталтаас хамгаалагч
210.	8543.90	Нислэгийн бичлэг хийх хэрэгслийн хоёр, эсхүл түүнээс дээш эд ангийг холбосон, эсхүл угсарсан багц, дэд багц
211.	8544.30	Агаарын хөлөгт зориулагдсан асаагуурын иж бүрдэл утас болон бусад иж бүрдэл утас
212.	8801.00	Аэростат (агаарын бөмбөлөг) болон дирижабль, планер, дельтаплан болон агаарын моторгүй бусад хөлөг
213.	8802.11	Хоосон цэвэр жин нь 2000 кг-аас ихгүй нисдэг тэрэг
214.	8802.12	Хоосон цэвэр жин нь 2000 кг-аас их нисдэг тэрэг



215.	8802.20	Хоосон цэвэр жин нь 2000 кг-аас ихгүй нисэх онгоц болон мотортой агаарын бусад хөлөг
216.	8802.30	Хоосон цэвэр жин нь 2000 кг-аас их боловч 15000 кг-аас ихгүй нисэх онгоц болон мотортой агаарын бусад хөлөг
217.	8802.40	Хоосон цэвэр жин нь 15000 кг-аас их нисэх онгоц болон мотортой агаарын бусад хөлөг
218.	8805.29	Мөр 8805.21-д дурдсан агаарын довтолгооны сургуулилтын төхөөрөмж, түүний эд ангиас бусад нисгэгчдийг газар дээр бэлтгэл хийлгэх төхөөрөмж, түүний эд анги
219.	8806.10	Зорчигч тээвэрлэхээр зохион бүтээгдсэн нисгэгчгүй агаарын хөлөг
220.	8807.10	Сэнс, ротор хөдөлгүүр, тэдгээрийн эд анги
221.	8807.20	Шасси болон түүний эд анги
222.	8807.30	Нисэх онгоц болон нисдэг тэрэгний 8807.10.00, 8807.20.00-д дурдсанаас бусад эд анги
223.	8807.90	Зүйл 88.01, 88.02, эсхүл 88.06-д заасан барааны бусад эд анги
224.	9001.90	Оптик боловсруулалтгүй шилнээс бусад ямар ч материалаар хийсэн байж болох, угсраагүй линз, призм, толь болон бусад оптик элемент
225.	9002.90	Оптик боловсруулалтгүй шилнээс бусад ямар ч материалаар хийсэн байж болох, багаж төхөөрөмжийн эд анги, тоног болгон ашиглах, дурангийн линз, эсхүл гэрлийн шүүлтүүрээс бусад суурилуулсан призм, линз, толь болон бусад оптик элемент
226.	9014.10	Чиг заагч луужин
227.	9014.20	Агаарын навигацид зориулсан (луужингаас өөр) багаж хэрэгсэл болон төхөөрөмжүүд
228.	9014.90	Чиглэл тодорхойлогч луужинд зориулсан эд анги болон дагалдах хэрэгсэл, агаарын навигацид зориулсан (луужингаас өөр) багаж хэрэгсэл болон төхөөрөмжүүд
229.	9020.00	Механик эд анги, солих шүүлтүүргүй хамгаалалтын баг, тэдгээрийн эд ангиас бусад амьсгалын хэрэгсэл болон хийн баг
230.	9025.11	Шингэн дүүргэгчтэй, шууд хэмжлийн, бусад багажтай хамт угсрагдаагүй термометр болон пирометр
231.	9025.19	Бусад багажтай хамт угсрагдаагүй термометр болон пирометр
232.	9025.80	Зүйл 90.25-д заасан бусад багаж
233.	9025.90	9025.11.00, 9025.19.00, 9025.80.00-д дурдсан багажийн эд анги болон тоног хэрэгсэл
234.	9026.10	Шингэний зарцуулалт, эсхүл түвшинг хэмжих, хянах багаж, аппарат
235.	9026.20	Хий, эсхүл шингэний даралт хэмжих, хянах багаж, аппарат



236.	9026.80	9026.10.00, 9026.20.00-д дурдсан багаж, аппаратаас бусад хий, эсхүл шингэний хувьсах хэмжигдэхүүнийг хэмжих, хянах багаж, аппарат
237.	9026.90	9026.10.00, 9026.20.00, 9026.80.00-д дурдсан багаж, аппаратын эд анги болон тоног хэрэгсэл
238.	9029.10	Эргэлтийн цахилгаан, эсхүл цахим тоолуур
239.	9029.20	Хурд заагч болон тахометр
240.	9029.90	Эргэлтийн тоолуур, хурд заагч болон тахометрын эд анги, тоног хэрэгсэл
241.	9030.10	Ионжуулагч цацрагийг хэмжих, эсхүл илрүүлэх багаж, аппарат
242.	9030.20	Осцилоскоп болон осциллограф
243.	9030.31	Цахилгааны хүчдэл, гүйдлийн хүч, эсэргүүцэл, эсхүл хүчин чадал зэрэг олон хэмжигдэхүүнийг хэмжих, эсхүл хянах универсал багаж (бичлэг хийх төхөөрөмжгүй)
244.	9030.32	Цахилгааны хүчдэл, гүйдлийн хүч, эсэргүүцэл, эсхүл хүчин чадал зэрэг олон хэмжигдэхүүнийг хэмжих, эсхүл хянах универсал багаж (бичлэг хийх төхөөрөмжтэй)
245.	9030.33	Олон хэмжигдэхүүнийг хэмжих универсал багаж (бичлэг хийх төхөөрөмжгүй)
246.	9030.39	9030.10.00, 9030.20.00, 9030.32.00-д дурдсанаас бусад цахилгааны хүчдэл, гүйдлийн хүч, эсэргүүцэл, эсхүл хүчин чадлыг хэмжих, хянах багаж, аппарат (бичлэг хийх төхөөрөмжтэй)
247.	9030.40	9030.10.00, 9030.20.00, 9030.32.00, 9030.39.00-д дурдсанаас бусад харилцаа холбооны салбарт ашиглагдах цахилгаан хэмжигдэхүүнийг хэмжих, хянах багаж, аппарат (бичлэг хийх төхөөрөмжтэй)
248.	9030.84	9030.10.00, 9030.20.00, 9030.32.00, 9030.39.00, 9030.40.00-д дурдсанаас бусад цахилгааны хэмжигдэхүүнийг хэмжих, хянах багаж, аппарат (бичлэг хийх төхөөрөмжтэй)
249.	9030.89	9030.10.00, 9030.20.00, 9030.31.00, 9010.32.00, 9010.33.00, 9030.39.00, 9030.40.00 эсвэл 9030.84.00-д дурдсанаас бусад цахилгааны хэмжигдэхүүнийг хэмжих, хянах багаж, аппарат
250.	9030.90	9030.10.00, 9030.20.00, 9030.31.00, 9010.32.00, 9010.33.00, 9030.39.00, 9030.40.00 эсвэл 9030.84.00, 9030.89.00-д дурдсан багаж, аппаратын эд анги болон тоног хэрэгсэл
251.	9031.80	90-р бүлгийн бусад газар заагдаагүй, эсхүл дурдаагүй хэмжих эсвэл хянах багаж, аппарат
252.	9031.90	9031.80.00-д дурдсан багаж аппаратын эд анги болон тоног хэрэгсэл
253.	9032.10	Термостат
254.	9032.20	Маностат
255.	9032.81	Шингэний, эсхүл хийн ажиллагаатай, автомат тохируулга, эсхүл удирдлагын багаж, аппарат



256.	9032.89	Автомат тохируулга, эсхүл удирдлагын бусад багаж, аппарат
257.	9032.90	Зүйл 90.32-т дурдсан автомат тохируулга, эсхүл удирдлагын багаж, аппаратын эд анги болон тоног хэрэгсэл
258.	9104.00	Хяналтын самбарын цаг болон агаарын хөлгийн зориулалттай түүнтэй төстэй цаг
259.	9109.10	Сэрүүлэгтэй цагнаас бусад өргөн, эсхүл диаметр нь 50 мм-ээс ихгүй, зай, аккумулятор, эсхүл тэжээлийг нийлүүлж угсарсан, эсхүл бүрэн цахим цагны механизм
260.	9109.90	Сэрүүлэгтэй цагнаас бусад өргөн, эсхүл диаметр нь 50 мм-ээс ихгүй, зай, аккумулятороос бусад хэсгийг нийлүүлж угсарсан, эсхүл бүрэн цагны механизм
261.	9401.10	Арьсаар бүрснээс бусад сандал
262.	9403.20	Сандлаас бусад металл тавилга
263.	9403.70	Сандлаас бусад хуванцар тавилга
264.	9405.10	Ханын, эсхүл таазны, үндсэн металл, эсхүл хуванцраар хийсэн цахилгаан гэрэлтүүлгийн хэрэгсэл
265.	9405.60	Үндсэн металл, эсхүл хуванцраар хийсэн гэрлэн хаяг, гэрлэн самбар болон эдгээртэй төстэй зүйлс
266.	9405.92	9405.10.00, 9405.60.00-д дурдсан зүйлсийн хуванцар эд анги
267.	9405.99	9405.10.00, 9405.60.00-д дурдсан зүйлсийн үндсэн металлээр хийсэн эд анги

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 4 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 164

Улаанбаатар
хот

Жагсаалт шинэчлэн батлах тухай

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 5.1.5, 5.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Жагсаалт шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 128 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Г.ЁНДОН

Засгийн газрын 2022 оны 164 дүгээр
тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЭРГЭЛТИЙГ ЗӨВШӨӨРӨХ, ОЛОН УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ БОЛОН ТЭДГЭЭРИЙН ҮНДСЭН ТҮҮХИЙ ЭДИЙН ЖАГСААЛТ

№	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн төрөл	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн төрлийн хэлбэрүүд	Барааны код
А	Б	В	Г
Нэг. Тэсэлгээний хэрэгсэл			
1.	Цахилгаан тэслүүр	агшны	3603
		удаашруулалттай	
		хамгаалалттай	
		газрын тос, хийн цооногийн	



2.	Галын бялт тэслүүр	Агшны хонгиотой	3603
3.	Цахилгаан бус тэслүүр	цахилгаан бус тэслүүрийн систем угсрах бэлдэц	3603
4.	Цахилгаан бус тэслүүрийн систем	цооног, шпурын Гадаргуугийн холбогч блоктой	3603
		цооногийн болон гадаргуугийн холбогч блоктой хосолсон	
5.	Цочир дамжуулах шижмийн гадаргуугийн удаашруулагч систем	цочир дамжуулах шижмээр холбох цохилтын долгион дамжуулах гуурстай холбогч блоктой	3603
6.	Цахим тэслүүр	утастай	3603
		утасгүй	
7.	Цочир дамжуулах шижим	гадаргуугийн холболтын бага хүчин чадлын	3603
		өндөр хүчин чадлын	
		газрын тос, хийн цооногийн	
8.	Цохилтын долгион дамжуулах гуурс	цахилгаан бус тэслүүрийн систем угсрах бэлдэц	3603
		тэсэлгээний холболтын шугамын, тэслүүргүй	
		тэсэлгээний холболтын шугамын, тэслүүртэй	
9.	Гал дамжуулах шижим		3603
10.	Гал дамжуулах шижмийн асаагуур	галын	3603
		цахилгааны	
Хоёр. Тэсрэх бодис			
11.	Цэнэг өдөөх тэсрэх бодисын хэрэгсэл бэлтгэх өндөр хүчин чадалтай тэсрэх бодис	RDX	121-82-4
		TNT	118-96-7
		PETN	78-11-5
		PETN, TNT холимог	8066-33-9
12.	Өдөөгч тэсрэх бодис	цооног, шпурын	3602
		чиглэсэн үйлчлэлтэй гадаргуугийн	
13.	Перфорацийн цэнэг	газрын тос, хийн цооногийн	3602
14.	Пресплитийн цэнэг	газрын тос, хийн цооногийн	3602
15.	Аммонит тэсрэх бодис	боодолтой, хамгаалалттай	3602
16.	Динамит тэсрэх бодис	бортоготой, чичирхийллийн	3602



17.	Гранулит тэсрэх бодис	мөхлөгтэй, задгай	3602
18.	Анфо тэсрэх бодис	энгийн найрлагатай, савлагаатай	3602
		нэмэлт хольцтой, савлагаатай	
		энгийн найрлагатай, задгай	
		хүнд анфо савлагаатай	
19.	Эмульсийн тэсрэх бодис	савлагаатай, тэслүүрт мэдрэмтгий	3602
		савлагаатай тэслүүрт, мэдрэмтгий бус	
		задгай	
		анфогийн хольцтой задгай	
Гурав. Үндсэн түүхий эд			
20.	Аммиакийн шүү	Аммиакийн шүү цэвэр	6884-52-2 6484-52-2
		Аммиакийн шүү сүвэрхэг	3102-30 3603
21.	Аммиакийн шүүний эмульс	Задгай, мэдрэгжүүлээгүй	дотоодод зөвшөөрөгдөх

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 183

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6.1.2, 6.1.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.



3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 359 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2022 оны 183 дугаар
тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЦӨМ ТЕХНОЛОГИЙГ
ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг зүйл

1.1.Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологи (цаашид “Тэргүүлэх чиглэл, цөм технологи” гэх)-ийг тодорхойлох үйл ажиллагааг зохицуулахад энэ журмыг мөрдөнө.

1.2.Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлохдоо Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Инновацийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, холбогдох бусад хууль, эрх зүйн баримт бичгийг үндэслэнэ.

1.3.Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлсноор төрөөс баталсан урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, дунд хугацаанд эдийн засгийн өсөлт, үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх, шинжлэх ухаанд зарцуулж байгаа төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

1.4.Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох үйл ажиллагаа нь Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 4.1, Инновацийн тухай хуулийн 4.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.1-д заасан зарчимд нийцсэн байна.

1.5.Тэргүүлэх чиглэл, цөм технологийг байгаль, нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн тодорхойлно.

Хоёр.Нэр томьёо

2.1.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“тэргүүлэх чиглэл” гэж байгаль, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн, үндэсний болон технологийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх салбарын болон салбар дундын ач холбогдолтой шинжлэх ухаан, технологийн сэдэвчилсэн чиглэлийг;

2.1.2.“цөм технологи” гэж тэргүүлэх чиглэлийн хүрээнд тодорхойлсон сэдэвчилсэн чиглэлийг хэрэгжүүлэх нөхцөлийг хамгийн ихээр хангахуйц, байгаль, нийгэм, эдийн засгийн салбарт шинжлэх ухаан, инновацийн ололтыг нэвтрүүлэх өргөн боломжтой, салбар болон салбар дундын шинжтэй технологийн шийдлийн цогцыг.

Гурав.Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох нийтлэг шалгуур үзүүлэлт

3.1.Тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо дараах шалгуур үзүүлэлтийг баримтална:

3.1.1.Монгол Улсын урт, дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичигт тодорхойлсон нийгэм, эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдсан байх;

3.1.2.үндэсний аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн байх;

3.1.3.Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдтэй холбоотой зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

3.1.4.хүний аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, амьдралын нөхцөлийг сайжруулах, хүний хөгжилд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байх;

3.1.5.дотоод, гадаадын зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээний үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийн технологи, үйлдвэрлэлийг дэмжсэн байх;

3.1.6. тогтвортой хөгжлийн зорилго, байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, доройтлыг бууруулах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад нийцсэн байх.

3.2. Тэргүүлэх чиглэлийн хүрээнд хөгжүүлэх цөм технологийг тодорхойлохдоо дараах шалгуур үзүүлэлтийг баримтална:

3.2.1. энэ журмын 3.1-д заасан шалгуур үзүүлэлтэд нийцсэн байх;

3.2.2. Монгол Улсад болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийгэм, эдийн засгийн үр өгөөж бүхий өндөр технологи байх;

3.2.3. шинжлэх ухааны суурь судалгааны үр дүнг хэрэглээнд нэвтрүүлсэн шинэ технологи байх;

3.2.4. инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгон хөгжүүлэхэд үндэс суурь болохуйц байх;

3.2.5. аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн байх;

3.2.6. үйлдвэрлэл, үйлчилгээний тэргүүлэх салбарт ашиглах боломжтой байх;

3.2.7. санхүү болон хүний нөөцийг үр ашигтай, оновчтой зохион байгуулахад чиглэсэн байх.

Дөрөв. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох үйл ажиллагаа

4.1. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох үйл ажиллагааг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага удирдан чиглүүлнэ.

4.2. Тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох ажлыг гүйцэтгэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Шинжлэх ухааны академи, яамдын шинжлэх ухаан, технологийн зөвлөл, агентлаг, эрдэм шинжилгээний болон их сургууль, орон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдүүлж шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталж ажиллуулна.

4.3.Ажлын хэсэгт зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Шинжээчдийн багийг Шинжлэх ухааны академи, эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, үйлдвэрийн газрын эрдэмтэн, тэргүүлэх мэргэжилтнүүдээс бүрдүүлж шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталж ажиллуулна.

4.4.Ажлын хэсэг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.4.1.тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох ажлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

4.4.2.тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтад санал авах болон тодотгол хийх холбогдох маягтыг боловсруулан батлуулах;

4.4.3.энэ журмын 4.4.2-т заасан маягтын дагуу Шинжлэх ухааны академи, яам, агентлагийн шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөл болон аймаг, нийслэл, их сургууль, эрдэм шинжилгээний болон хувийн хэвшлийн холбогдох байгууллагаас санал авах;

4.4.4.тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтын төслийг боловсруулахад үр нөлөө, хүрэх үр дүнгийн төсөөлөл бүхий үнэлгээний аргачлалыг боловсруулан батлуулах;

4.4.5.тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох нарийвчилсан шалгуур үзүүлэлтийг энэ журмын нийтлэг шалгуур үзүүлэлтийн хүрээнд нийцүүлэн тодорхойлж батлуулах;

4.4.6.тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох үе шат, түүнд татан оролцуулах хүний болон бусад нөөцийг тогтоох, тухайн үед шийдвэрлэх шаардлагатай асуудлаар холбогдох арга хэмжээг зохион байгуулах;

4.4.7.тэргүүлэх чиглэл, цөм технологийн томьёолол, үр нөлөө, хүрэх үр дүнгийн төсөөлөл болон хэрэгжүүлэх саналыг боловсруулах;

4.4.8.тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтыг батлагдсан аргачлал, шалгуур үзүүлэлтийн дагуу Шинжээчдийн багийн санал, дүгнэлтийг тусган эцэслэн боловсруулж, шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

4.5.Шинжээчдийн баг дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

4.5.1.тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл бүрдүүлэх зорилгоор ажлын хэсгийн явуулсан судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийх;

4.5.2.тэргүүлэх чиглэл, цөм технологийн томьёоллыг нарийвчлах санал боловсруулах, тэдгээрийн хүрээнд бий болгох бүтээгдэхүүн, үйлчилгээний үзүүлэлтийг үнэлэх, онц чухал ач холбогдолтой технологийн жагсаалтад нэмэлт оруулах зорилгоор хянан магадалгаа хийх;

4.5.3.хянан магадалгаа хийсэн шинжээчид чухал ач холбогдолтой бүтээгдэхүүн, үйлчилгээний болон тэдгээрийн үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай технологийн жагсаалт, тэргүүлэх чиглэл, цөм технологийн төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналаа нэгтгэн боловсруулж ажлын хэсэгт ирүүлэх;

4.5.4.тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх арга хэмжээний саналд дүн шинжилгээ хийх.

4.6.Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.6.1.тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтад нэгдсэн үнэлгээ хийх, улсын байгаль, нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл, цөм технологийг холбогдох яам, Шинжлэх ухааны академи, их, дээд сургууль, мэргэжлийн холбоодын саналыг авч эцэслэн боловсруулах;

4.6.2.тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7.2.2-т заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулах;

4.6.3.тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтыг Засгийн газраар батлуулах;

4.6.4.тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох болон тодотгол хийх ажлыг 3 жил тутамд гүйцэтгэх.

4.7.Улс орны байгаль, нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ, төрөөс баримтлах урт, дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцүүлэн Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологид тодотгол хийж болно.



Тав.Тэргүүлэх чиглэл, цөм технологийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1.Тэргүүлэх чиглэл, цөм технологийг хэрэгжүүлэх ажлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох яам, агентлаг, байгууллагуудтай хамтран тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

5.2.Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тэргүүлэх чиглэл, цөм технологийн хүрээнд хөтөлбөр, төсөл боловсруулан улс орны байгаль, нийгэм, эдийн засгийн хөгжлийн стратегийн зорилтыг хангах бүтээгдэхүүн, үйлчилгээний технологийн судалгааг тэргүүн ээлжинд санхүүжүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 188

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50.11, 50.13-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Мөнгөн урамшуулал олгоход шаардагдах зардлыг 2023 оноос үе шаттайгаар улсын төсөвт тусгаж шийдвэрлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН



Засгийн газрын 2022 оны 188 дугаар
тогтоолын хавсралт

**АЙМГИЙН ТӨВӨӨС БУСАД СУМАНД ТАСРАЛТГҮЙ ТАВ БОЛОН
ТҮҮНЭЭС ДЭЭШ ЖИЛ АЖИЛЛАЖ БАЙГАА ОНЦГОЙ БАЙДЛЫН
БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИД МӨНГӨН УРАМШУУЛАЛ
ОЛГОХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал (цаашид “мөнгөн урамшуулал” гэх)-ыг олгоход энэ журмыг мөрдөнө.

Хоёр.Мөнгөн урамшуулал олгох хугацаа, хэмжээ

2.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч (цаашид “алба хаагч” гэх) аймгийн төвөөс бусад суманд томилогдсон өдрөөс эхлэн тасралтгүй 60 сар ажилласан бол түүнд таван жил тутам нэг удаа мөнгөн урамшуулал олгоно.

2.2.Мөнгөн урамшуулал тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтооходоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 60 сарын дунджаар тооцно. Энэ үндсэн цалингийн дунджийг 30 сараар үржүүлж мөнгөн урамшууллын хэмжээг тогтооно.

2.3.Аймгийн Онцгой байдлын газар тухайн алба хаагчийн ажилласан хугацаа, албан тушаалын сарын үндсэн цалинг үнэн зөв тодорхойлно.

Гурав.Мөнгөн урамшуулал олгох

3.1.Энэ журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан алба хаагч мөнгөн урамшуулал авах хүсэлтээ тухайн аймгийн Онцгой байдлын газарт бичгээр гаргана.

3.2.Аймгийн Онцгой байдлын газар тухайн алба хаагчийн хүсэлт, ажилласан хугацаа, сүүлийн 60 сарын албан тушаалын үндсэн цалингийн хэмжээг тодорхойлсон тодорхойлолт, томилогдсон тушаал, шийдвэр (шаардлагатай тохиолдолд архивын лавлагаа)-ийн хуулбарын хамт онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.



3.3.Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ирүүлсэн баримт бичгийн бүрдэл, алба хаагчийн ажилласан жилийг хянаж, баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан мөнгөн урамшуулал олгох эсэх шийдвэрийг гаргана.

3.4.Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг үндэслэн урамшууллын мөнгийг тухайн алба хаагчийн дансанд 30 хоногийн дотор шилжүүлнэ.

3.5.Энэ журмын 2.1-д заасан нөхцөлийг хангаж, мөнгөн урамшуулал авах хүсэлт гаргасан алба хаагч нас барсан тохиолдолд мөнгөн урамшууллыг түүний гэр бүлд нь олгоно.

3.6.Аймгийн Онцгой байдлын газар мөнгөн урамшуулал олгох алба хаагчийн тоо, шаардагдах зардлын хэмжээг тооцон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 1 дүгээр сард багтаан хүргүүлнэ.

3.7.Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мөнгөн урамшуулалд шаардагдах зардлыг байгууллагынхаа жил бүрийн төсөвт тусгана.

Дөрөв.Бусад

4.1.Энэ журмын 2.1-д заасан тасралтгүй 60 сар ажилласан хугацаанд Төрийн албаны тухай хуулийн 42.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 60.1.3, 60.1.5, 60.1.12-т заасны дагуу ажил үүргээ гүйцэтгээгүй хугацааг оруулахгүй.

4.2.Алба хаагчийн ажилласан хугацаа, үндсэн цалингийн дундаж хэмжээг буруу тодорхойлох, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зэргээр мөнгөн урамшууллын хэмжээг буруу тогтоож олгосон эсхүл авсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2022 оны 08 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 17.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр, Ш.Солонго, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү, Ц.Нанзаддорж, Г.Баясгалан, Ж.Эрдэнэбулган /илтгэгч/, Д.Гангабаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар оролцов.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаар дахин хянан хэлэлцлээ.

Нэг. Монгол Улсын иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх нар Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл, нэмэлт тайлбар ирүүлсэн байна:

“Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Гуравдугаар зүйлийн 10 дахь заалтаар Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” хэмээн өөрчлөн найруулсан. Ийнхүү өөрчлөн найруулж “Ерөнхий сайд

болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Оршил хэсгийн “Монголын ард түмэн бид: ... хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. ...”, Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.”, Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.”, Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасантай тус тус зөрчилдөж байна.

1.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулиар бүгд найрамдах улсын хэлбэрийг нутагшуулан авсан. Төрийн удирдлагын парламентын бүгд найрамдах улсын хэлбэртэй улсад кабинетын зарчмыг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын тэргүүн нь өөрийн Засгийн газрын бүрэлдэхүүнийг дангаар мэдэн бүрдүүлж, парламентынхаа өмнө хариуцлага хүлээдэг. Энэ хүрээнд парламент буюу Улсын Их Хурал Засгийн газрын бүрэлдэхүүнээс зөвхөн Ерөнхий сайдыг өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд томилох ба гишүүдийг Ерөнхий сайд өөрөө томилдог байхаар тогтоосон.

Эл үзэл баримтлалыг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3, 4, Дөчин нэгдүгээр зүйлийн 1, Дөчин гуравдугаар зүйлийн 2, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 2, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт бодит үйл явц болгон хуульчилсан байна.

Өөрөөр хэлбэл, парламентын засаглал бүхий улс орнуудад эдүгээ нийтлэг хүлээн зөвшөөрөгдөх болсон Ерөнхий сайд Засгийн газраа өөрөө мэдэж бүрдүүлдэг, Ерөнхий сайд Засгийн газраа бүрдүүлэх бүрэн



эрхийг хязгаарладаггүй, нэг талаас Засгийн газрын гишүүн буюу сайд нь парламентын гишүүн байх, нөгөө талаас парламентын гишүүн нь Засгийн газрын гишүүн буюу сайд байх боломжтой байдаг, төрийн албаны болон улс төрийн арвин туршлага, өндөр мэдлэгтэй шилдэг хүмүүсээр Засгийн газраа бүрдүүлдэг жишгийг монголчууд бид Үндсэн хуульдаа тусгасан.

Гэтэл Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Гуравдугаар зүйлийн 10 дахь заалтаар Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийг өөрчлөн найруулахдаа “... Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Оршил хэсэг, дээр дурдагдсан төрийн эрх мэдлийн хуваарилалтад холбогдох заалтууд, Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь үзэл санаанд харшилсан төдийгүй, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтоор баталгаажсан Ерөнхий сайдын онцгой бүрэн эрхийг хязгаарласан байна.

Энэ нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын харилцаа, хяналт, тэнцвэрт сөргөөр нөлөөлж, Засгийн газрын үйл ажиллагааны чадавх, тогтвортой байдал алдагдах, парламент дахь улс төрийн намуудын хүчний харьцаанаас шалтгаалан зөвшилцлийн үр дүнд бий болсон Засгийн газар нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн оронд огцрохоос зайлсхийсэн, аргацаасан үйл ажиллагаа явуулдаг болох, Улсын Их Хуралд нөлөөлөл, харилцаа холбоо багатай сайдуудын хариуцсан салбарын ажил хэрэг уналтад орох гэх мэт сөрөг нөхцөл байдлууд үүсэж, төрийн хямралд хүргэхээр байна.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.” гэж заасан нь Улсын Их Хурлын бүх гишүүдэд адил боломжийг нээж өгсөн зохицуулалт бөгөөд 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Гуравдугаар зүйлийн 10 дахь заалт нь дээрх заалттай зөрчилдөж байна. Уг зөрчилтэй заалтыг нэмснээр Улсын Их Хурлын гишүүдийн тэгш байдлыг алдагдуулж, Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь үзэл санаанд харшилсан зохицуулалт болжээ.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн

байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасан тул Улсын Их Хурлаас батлан гаргасан бүх шийдвэр, түүний дотор Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь эдүгээ мөрдөгдөж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, даяар олноо зарлан тунхагласан Оршил хэсэг болон тухайн нэмэлт, өөрчлөлтөөр хөндөгдөөгүй бусад зүйл, заалтуудад бүрнээ нийцэж байх ёстой билээ.

Чөлөөт ардчилсан, эрх зүйт төртэй дэлхийн улсуудад Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуульт байгуулал, Үндсэн хуульт ёс, Үндсэн хуулийнхаа суурь үзэл санаа, үнэт зүйлсийг хамгаалагч, чандлан сахиулагч, Үндсэн хуулийг тайлбарлан хөгжүүлэгч нь байдаг тогтсон ёс бий. Үндсэн хуулийн цэц ч Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгээр тогтоогдсон дээрхтэй адилтгах чиг үүргээ биелүүлж, нэгэнт үүсээд байгаа маргааныг магадлан шийдвэрлэх шаардлага эдүгээ тулгараад байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Гуравдугаар зүйлийн 10 дахь заалтад “... Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэж заасан нь уг нэмэлт, өөрчлөлт батлагдахаас өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтууд болон бусад заалтуудтай зөрчилдөж байгаа талаар, мөн 1992 оны ардчилсан Үндсэн хуулийн суурь үзэл санаанд нийцэхгүй, дордуулсан агуулгатай батлагдсан талаар шийдвэр гаргаж өгнө үү.” гээд,

Нэмэлт тайлбартаа, “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль /цаашид “Үндсэн хууль” гэх/-ийн бүлэг, зүйл, хэсэг, заалтад байхгүй шинэ томъёолоор зохих бүлэгт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтыг Үндсэн хуулийн нэмэлт гэх бөгөөд тэр нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцсэн байна.”, мөн зүйлийн 2.4 дэх хэсэгт “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалыг өөрчлөх буюу нийт зүйлийн 35, түүнээс дээш хувийг өөрчлөх, эсхүл түүнтэй тэнцэх тоо хэмжээний нэмэлт оруулахаар байвал энэ нь Үндсэн хуулийг бүхэлд нь өөрчлөх буюу хянан үзэхэд хамаарна.” гэж заасан болон Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар бүлгийн зохицуулалтаас үзэхэд Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд харшилсан, түүнийг өөрчилсөн Үндсэн хуулийн



нэмэлт, өөрчлөлтийн талаар үүссэн маргааныг Үндсэн хуулийн цэц харьяалан шийдвэрлэх бүрэн эрхтэй байна.

Мөн 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр төрийн эрх мэдэл хоорондын хяналт-тэнцлийг хангахын тулд Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллах тоог хязгаарлах, хориглох зарчмаар бус Үндсэн хуулийнхаа суурь үзэл баримтлалд нийцүүлэн, иргэдийн эрхийг хангасан, засаглалын салаа мөчир бүрийн үр ашигтай байдлыг хангахуйц, олон улсын парламентын ардчиллын хөгжлийн чиг хандлага, манай улстай төстэй төрийн эрх мэдлийн “зөөлөн” хуваарилалт бүхий улсуудын сайн жишигт нийцүүлэн Улсын Их Хурлын гишүүдийн тоог 150-аас дээш байхаар тогтоож, Үндсэн хуулийнхаа суурь үзэл баримтлал, үндсэн бүтцийг хадгалсан байдлаар шийдэх нь зохистой байсан.

Иймд Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсран гүйцэтгэх асуудлыг Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал, төрийн эрх мэдлийн хуваарилалтын хяналт-тэнцлийн зарчмыг алдагдуулахгүй байх зорилгын үүднээс Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэгдүүлэх, сонгох, сонгогдох эрхийн баталгааг бүрэн хангасан сонгуулийн тогтолцоог хуульчлан тогтоох асуудалтай нягт холбоотой, иж бүрнээр нь шийдвэрлэх ёстойг Цэцээс магадлан тогтоох шаардлагатай юм.

Цэцийн зүгээс бидний мэдээлэл, түүний тайлбар, үндэслэлд дурдагдсан дээрх хоёр асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн орчинд гаргасан өөрийн шийдвэрүүдийн хоорондын зөрчилдсөн шинжтэй, харилцан адилгүй агуулгуудыг Үндсэн хуулийн агуулга, суурь үзэл баримтлал, шинээр үүссэн Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтуудад нийцүүлэн нэг мөр болгон, эцэслэн шийдвэрлэж өгнө үү.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын иргэн Ш.Адъяаа, Н.Ганибал нар Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл ирүүлсэн байна. Үүнд:

“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, даяар олноо зарлан тунхагласан Оршил хэсэг болон зүйл, заалтад сүүлд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь бүрнээ нийцэж байх ёстой билээ.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь үзэл баримтлалын хувьд Үндсэн хуульд нийцэж байгаа боловч Гуравдугаар зүйлийн зарим хэсэг нь эх Үндсэн хууль, түүний агуулга, үзэл баримтлалд нийцээгүй, зөрчилтэй болсон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, нэн шинэ зохицуулалт ёсоор Ерөнхий сайд Засгийн газраа бүрдүүлж, хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах чиг үүргийг хэрэгжүүлж үр дүнг нь өөрөө бүрэн хариуцдаг дэлхийн улс орнуудад хэдийн шалгагдсан гүйцэтгэх эрх мэдлийн загварыг хүлээн авахаар шийдвэрлэсэн бөгөөд энэ хүрээнд парламент буюу Улсын Их Хурал Засгийн газрын бүрэлдэхүүнээс зөвхөн Ерөнхий сайдыг өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд томилж ба гишүүдийг Ерөнхий сайд өөрөө томилдог байхаар тогтоосон.

Манай улстай Засгийн газраа бүрдүүлэх адил төсөөтэй арга, механизм бүхий дэлхийн улс орнуудад Ерөнхий сайд Засгийн газраа бүрдүүлэх бүрэн эрхийг хязгаарладаггүй. Өөрөөр хэлбэл, нэг талаас Засгийн газрын гишүүн буюу сайд нь парламентын гишүүн байх, нөгөө талаас парламентын гишүүн нь Засгийн газрын гишүүн буюу сайд байх боломж нөхцөл цөм бүрдсэн байх бөгөөд алсын хараа, хэтийн бодлоготой, эх орноо хөгжүүлэх үйлс, санаачилгад бодол санаа нь цэгцэрсэн, улс төрийн хувьд туршлагатай хүмүүсээр Засгийн газраа бүрдүүлдэг байна. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Гуравдугаар зүйлийн 10 дахь заалтаар Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийг өөрчлөн найруулахдаа "... Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно." гэж заасан нь 1992 онд батлагдсан эх Үндсэн хуулийн хэд хэдэн заалт болон хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтоор баталгаажсан Ерөнхий сайдын онцгой бүрэн эрхийг хязгаарласан байна.

Өнгөрсөн 29 жилийн түүхэн сургамжаас авч үзвэл, (1) Засгийн газар бүрэлдэхүүнээрээ Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлаас хэт хараат байсны улмаас үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн оронд тэдэнд таалагдахын төлөө ажиллах шаардлага байнга гарч байсан бөгөөд цаг үргэлж ийм байх боломжгүй тул 1-1.5 жил болоод Засгийн газар огцордог байсан практик улам даамжирч нэг жил, бүр сар хүрэхгүй хугацаанд ажиллах Засгийн газартай болох нөхцөлийг бүрдүүлсэн байна; (2) Парламентын гишүүн Засгийн газрын гишүүнээр ажиллах боломж хомс, хязгаарлагдмал тул улс



төрчид улс орноо хөгжүүлэх мөрийн хөтөлбөрийн дор нэгдэж сонгуульд нэр дэвшихийн оронд сонгуулийн компанит ажлын санхүүжүүлэгч болон бусад оролцогч болон хувирч, үүнийхээ шанд сайдын албан тушаал горилогч болохоор байна. Энэ нь алс хэтдээ парламентын засаглалыг хямралд оруулахаар байна; (3) Нийгмийн амьдрал, үйл явц нь парламентын гишүүдэд өөрийн салбарын зовлон, жаргалыг ажралгүй ойлгуулж, зөв зүйлийн төлөө манлайлал үзүүлдэг, туршлагатай улс төрчдөөс Засгийн газрыг бүрдүүлэхийг шаардах боллоо. Эл байдал хүнд, амаргүй энэ цаг үед ил тодорхой мэдрэгдэж байна; (4) Парламентад хэд хэдэн нам суудалтай болж бүлэг байгуулсан тохиолдолд сайд томилуулахын төлөө зөвшилцөж үл чадах мэтгэлцээн, зөрчилд хүргэж улмаар засаглалын хямралыг үүсгэхээр байна; (5) Парламентад суудалтай хэд хэдэн нам зөвшилцөж Засгийн газрыг бүрдүүлж чадлаа ч гэсэн зарим нэг бодлого, шийдвэрийн талаар санал нэгдэхгүй байдал нь Засгийн газрын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж, гацаанд оруулна; (6) Засгийн газар огцрох, эс огцрох нь парламентын 19 гишүүний саналаас шууд шалтгаалах тул үндсэндээ гишүүдэд тал засдаг Засгийн газар бий болж, үүний үр дагавар нь гүйцэтгэх эрх мэдлийг парламентын гишүүд хуваан авч төлөөлүүлэн удирддаг болохоор байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Оршил хэсэгт “Монголын ард түмэн бид: улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.” гэснээс үзвэл Монгол Улс засаглалын хямралгүй, аливаа засаглалын хямралаас болж хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдэлд сэв суудаггүй, өргөн ардчилал бүхий улс байхаар байна. Тийм байхад Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь мөн чанарын хувьд Үндсэн хуулиар зохицуулах шаардлагагүй Засгийн газрын дөрвөн гишүүн Улсын Их Хурлын гишүүн байж болох тухай тусгах замаар Үндсэн хуулийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд хязгаарлалт тогтоосон байна. Дээрх зөрчилтэй заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчиж байна.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх нэмэлт, өөрчлөлтөд Улсын Их Хурлын гишүүдээс дөрөв хүртэл хүнийг Засгийн газрын гишүүнээр томилон ажиллуулж болохоор заасан нь Ерөнхий сайд Засгийн газраа

бүрдүүлж, улмаар хариуцлагыг өөрөө хүлээдэг байх үзэл баримтлалын илэрхийлэл болсон Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. ...”, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Засгийн газрын гишүүнийг ... Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. ...”, Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.” гэж тус тус заасантай агуулгын хувьд зөрчилдөж байгаа болно.” гэсэн байна.

Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

“... 1.Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “... Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэж өөрчлөн найруулсан үндэслэл, шаардлагын тухайд:

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Үндсэн хууль бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын гишүүний дийлэнх олонхи нь хүрэлцэн ирснээр чуулганыг хүчинтэйд үзэж, чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.” гэж, Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй.” гэж тус тус заасан байсныг 2000 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. ...”, “... Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.” гэж тус тус өөрчилсөн байдаг.

Дээрх өөрчлөлтийн улмаас чуулганы хуралдаан багадаа 51 гишүүн оролцсоноор хүчин төгөлдөрт тооцогдож, тэдгээрээс 26 гишүүн нь дэмжсэнээр хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр батлагддаг байсан босго буурч, чуулганы хуралдаанд 39 гишүүн оролцсоноор хүчин төгөлдөрт тооцогдож, 20 гишүүний дэмжлэгээр хууль батлах боломжийг бүрдүүлсэн. Мөн Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хавсрах боломжтой болсон. ...



Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан Ажлын хэсгийн зүгээс парламентаар хууль эцэслэн батлах босго болон парламентын гишүүний бүрэн эрхтэй үл нийцэх алба, ажлын талаар буюу хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын хяналт-тэнцлийг хангах чиглэлээр судалгаа хийсэн байдаг. ...

Улсын Их Хурлаас дээрх судалгааны дүгнэлт, дэлхийн улсуудын хууль тогтоомж, туршлагыг харгалзан үзэж, 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийг “Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар хуулийг эцэслэн батална.” гэж өөрчилж, хуулийг эцэслэн батлах босгыг үнэмлэхүй олонхоор буюу 39 ба түүнээс дээш гишүүний саналаар тогтоосон.

Энэ нь хуулийг батлах босгыг даруй 19-өөр нэмэгдүүлж, улмаар Засгийн газраас парламентын хууль тогтоох бүрэн эрхэд нөлөөлөх нөлөөллийг хязгаарлаж, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын хяналт-тэнцлийг хангахад чухал ач холбогдолтой зохицуулалт болсон юм. Түүнчлэн хуулийг эцэслэн батлах босгыг өндөрсгөсөн дээрх өөрчлөлт нь Монгол Улсын хувьд парламентын гишүүн Засгийн газрын гишүүнийг хавсран ажиллахыг хатуу хориглох, эсхүл бүрэн нээлттэй байлгах, тооны хязгаар тогтоох эсэхийг Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэх өргөн боломжийг олгосон. Тийм ч учраас 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “... Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэж өөрчлөн найруулсан. ...

Дэлхийн улсуудын хууль тогтоомж, туршлагаас харахад парламентын гишүүн нь цөөн тоотой бол хавсран гүйцэтгэхийг хориглох хандлагатай байна. Харьцангуй цөөн гишүүнтэй, нэг танхимтай парламент бүхий Монгол Улсын хувьд парламентын гишүүн Засгийн газрын гишүүнийг хавсран ажиллахыг хатуу хориглох, эсхүл бүрэн нээлттэй байлгах нь онолын хувьд ч, туулж ирсэн туршлагаас үзэхэд ч тохирохгүй нь илэрхий болсон гэж үзэн уг хоёр албан тушаалыг хавсарч болох зохистой заагийг тогтоох үүднээс Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “... Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын

гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэж өөрчлөн найруулсан. Ингэснээр Улсын Их Хурал, Засгийн газрын чиг үүргийн давхцал арилж, тэдгээрийн чиг үүргийн ялгаа илүү тодорхой болох, бие биеэсээ хараат бусаар Үндсэн хуулиар тогтоосон бүрэн эрхээ гадны ямар нэг нөлөөгүй хэрэгжүүлэх боломж бүрдэнэ, хууль тогтоох-гүйцэтгэх эрх мэдлийн хооронд хяналт-тэнцэл сонгодог утгаараа хэрэгжинэ гэж үзсэн.

2.Үндсэн хуульд заасан Ерөнхий сайдын бүрэн эрхийг хязгаарласан эсэх тухайд:

Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийг өөрчлөн найруулснаар Засгийн газрын тогтвортой байдлыг хангахтай холбоотойгоор Улсын Их Хурал Засгийн газрын гишүүн-сайд нарыг хүн бүрээр хэлэлцэн томилох өөрийн бүрэн эрхээсээ татгалзан, Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, ажлаа Улсын Их Хурлын өмнө хариуцах, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа Ерөнхий сайдын бүрэн эрх эхэлж, дуусгавар болохтой шууд хамааралтай байх, Ерөнхий сайд Засгийн газраа өөрөө бүрдүүлэх зэрэг Засгийн газар танхимын зарчмаар үйл ажиллагаа явуулахыг тогтоож өгсөн.

Гүйцэтгэх засаглалын тэргүүн улс төрийн сонгуульд ялсан намын мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд парламентын гишүүдийн улс төрийн дэмжлэг чухал бөгөөд Засгийн газрын үйл ажиллагаа тогтвортой байхад ч шийдвэрлэх нөлөөтэй. Тиймээс олон улсын парламентын сайн практикт Ерөнхий сайд Засгийн газрыг тогтвортой байлгаж, бодлогын асуудлаа түргэн шуурхай шийдвэрлүүлэх, томоохон төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэх, үр дүнд хүргэхэд улс төрд нөлөөтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, бүх ард түмний сонгуулиар ялалт байгуулсан хүнийг ямарваа тоон хязгаарлалтын шахалтад орохгүйгээр багтаа авч ажиллуулахыг чухалчлан авч үзэх нь зүйн хэрэг.

Гэхдээ хүн ам цөөнтэй, парламентын нэг гишүүнд ногдох хүн амын тоо өндөр, төлөөлөх чадвар сул, нэг танхимтай зэрэг Монголын парламентын өнөөгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан Улсын Их Хурлын гишүүн нь Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран ажиллахад тодорхой тоон хязгаарлалт байх нь зүйтэй гэж хууль тогтоогчид үзсэн ба ингэснээр Ерөнхий сайдад Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхийг хөндөхгүй гэж үзсэн.

3. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран гүйцэтгэхэд хязгаарлалт тавих нь Үндсэн хуулийн зөрчилд хүргэх эсэх тухайд:

... Улсын Их Хурлын гишүүд нь Засгийн газрын бүрэлдэхүүнд тогтоосон тоон хязгааргүйгээр орж ажиллах нь хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд гарах зарим шийдвэр нь Засгийн газрын хүсэл зоригоор шийдвэрлэхэд хүрдэг гэж судлаачид үздэг байна. 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр чуулганы кворум буюу хүчин төгөлдөрт тооцогдох шалгуурыг ердийн олонхи байх өөрчлөлтийг хийснээр 20 гишүүн хууль батлах боломжийг бүрдүүлсэн. Улсын Их Хурлаас 2019 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар 39 ба түүнээс дээш гишүүн дэмжсэнээр хууль баталдаг болсноор хууль тогтоох үйл ажиллагаанд Засгийн газрын хүсэл зоригийг хязгаарлахад бодит алхам болсон ба гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдлийн хяналт-тэнцлийг алдагдуулахад хүргэж болох эрсдэлийг бууруулсан гэж үзэж болно. ...

Үндсэн хуулийг анх батлах үед Улсын Их Хурлын 76 гишүүнийг тухайн үеийн сонгуулийн насны иргэдийн тоонд үндэслэн харьцуулан нэг гишүүн 15-20 мянган сонгогчийг төлөөлнө гэсэн замаар оруулсан байдаг. 1992 онд 2.1 сая хүн амтай байсан бол өдгөө 3.3 сая хүн амтай болж 1 гишүүн дунджаар 42.7 мянган хүн амыг төлөөлөх болсон байна. Энэ нь манай улсын нэг Улсын Их Хурлын гишүүн Бүгд Найрамдах Эстони Улсын парламентын гишүүнээс 3.4 дахин их, Бүгд Найрамдах Ардчилсан Зүүн Тимор Улсаас 4.6 дахин их, хүн амын тоо ойролцоо Бүгд Найрамдах Армен Улсаас 1.8 дахин их иргэдийг төлөөлж байгаа юм. Тиймээс судлаачид Улсын Их Хурлын гишүүдийн тоог хүн амын тоотой уялдуулан, төлөөллийн зарчмыг илүү сайн хангуулах үүднээс нэмэх, цаашид Үндсэн хуулийн хүрээнд уг асуудлыг авч үзэх бодит шаардлага бий болсон гэж үздэг.

Үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд сонгодог парламентын засаглалтай улсад улс төрийн нам, сонгуулийн тогтолцоо гол үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнийг хавсран гүйцэтгэхэд улс төрийн сонгуулийн тогтолцоо, түүний үр дүнд гарч ирэх хүчнүүдийн харьцаа чухал нөлөөтэй. Сонгуулийн холимог тогтолцооны үед улс төрийн нам парламентад олонхийг бүрдүүлж чадаагүй үед суудал авсан намууд эвсэх, эвслийн Засгийн газар байгуулан ажиллах нөхцөл байдал үүснэ.

Улс төрийн энэ нөхцөлд суудал авсан улс төрийн намуудаас намын лидерүүд нь гүйцэтгэх эрх мэдлийн бүрэлдэхүүнд орж шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох зайлшгүй шаардлага бий болно. Энэ үед хавсран гүйцэтгэхэд тавигдах тоон шаардлагыг биелүүлэхэд тодорхой хүндрэлүүд үүсэж болно. Улмаар ээлжит улс төрийн тогтворгүй, хямралт байдал руу оруулах, Засгийн газрыг огцруулах таагүй үр дагаврыг бий болгоно. Улс төрийн хүчтэй нөлөө бүхий гишүүдээ Засгийн газрын бүрэлдэхүүнд оруулахын тулд парламентын гишүүний бүрэн эрхээс татгалзах, дахин сонгууль явуулах, энэ нь парламент дахь улс төрийн хүчний харьцаа, олонхи, цөөнх байхад нөлөөлөх зэрэг эцсийн дүнд улс төрийн тогтворгүй орчныг бий болгох эрсдэлтэй.

Судлаачид Улсын Их Хурлын гишүүдийн тоо 120-150 байх ёстой гэж үздэг. Ингэхдээ иргэдийн төлөөллийг тэгш хангах, мөн газар нутгаа төлөөлөх гэсэн хоёр асуудлыг аль алиныг хангасан Үндсэн хуулийн тогтолцоог сонгох шаардлагатай талаар олон судлаачид үзэж, энэ талаар нэлээдгүй судалгаа хийгдсэн байна. ...

Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэгдүүлэх, сонгуулийн холимог тогтолцоог бүрдүүлсэн нөхцөлд Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэснээр төрийн эрх мэдлийн хяналт-тэнцлийг алдагдуулах бодит шалтгаан арилна гэж үзэж байна.

Парламентын гишүүд Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллахад парламентаас Засгийн газарт тавих хяналт суларна гэж үзэх хандлага байдаг. Гэвч парламентын хяналт шалгалтын бүрэн эрхийг илүү үр нөлөөтэй болгосноор хуульд заасан хяналт шалгалтын арга хэлбэрүүдээр дамжуулан заавал тооны хязгаар тавихгүйгээр эрх мэдэл хоорондын хяналт-тэнцэл хангагдах нөхцөл болно гэж үзэж байна.

Дээр дурдсаныг үндэслэн дүгнэхэд Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Гуравдугаар зүйлийн 10 дахь заалтаар Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг "... Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно." гэж өөрчлөн найруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Оршил, Нэгдүгээр зүйлийн 2, Хорин есдүгээр зүйлийн 1, Гучин есдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэх боломжгүй бөгөөд төрийн эрх мэдлийн хуваарилалтын онол, түүнийг Монголын нөхцөлд нутагшуулахад харгалзан үзэх онцлог, уламжлал, улс

төрийн орчин, парламентын засаглалд үүсэж байсан хямралт байдал, практикийн асуудлууд, сонгуулийн тогтолцоо зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэж шийдвэрлэсэн болно.” гэсэн байна.

Дөрөв. Монгол Улсын Их сургуулийн дэргэдэх Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнг шинжээч хийх байгууллагаар томилсон бөгөөд онолын болон олон улсын туршлагыг судлан харьцуулалт хийж дараах агуулга бүхий дүгнэлтийг хийжээ. Үүнд:

“... 1. Парламентын гишүүн Засгийн газрын гишүүний албыг давхар хашихыг хориглох эсхүл зөвшөөрөх нь тухайн орны төрийн удирдлагын тогтолцоо, парламентын танхимын тоо болон гишүүдийн тоо зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай. Онолын болон практикийн талаас нь авч үзэхэд парламентын гишүүн сайд байх нь (1) хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэл хоорондоо уусаж нягт холбоотой ажиллах, (2) сайд болох боломжтой хүмүүсийг иргэд урьдчилан сонгох, (3) кабинетыг хүчирхэгжүүлэхийн зэрэгцээ хүчний тэнцвэр үүсгэх, (4) парламентаас засгийн газарт тавих хяналт хэрэгжих зэрэг давуу талтай байна. Харин парламентын гишүүн сайд байхыг хориглосноор (1) хууль тогтоох эрх мэдлийн бие даасан байдлыг сулруулах, түүнд Засгийн газрын нөлөөллийг нэмэгдүүлэхээс сэргийлэх, (2) хоёр албан тушаалыг зэрэг хаших боломжгүй, (3) тал талын төлөөллийг хангасан мэргэжлийн хүмүүсээр Засгийн газрыг бүрдүүлэх, (4) засгийн газрын хэт улс төржилтийг бууруулах сайн талтай байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн улсын парламентын тогтолцоо, гишүүдийн тоо, танхимын тоог харгалзан үзэхийн зэрэгцээ, сайд Улсын Их Хурлын гишүүн байхыг “яагаад” зөвшөөрөх эсхүл хориглох шаардлагатай тухай “онолын болон практик”-ийн үндэслэлээ зөв тодорхойлох нь чухал юм. ...

2. Судалгааны хүрээнд судалсан парламентын засаглалтай 38 улсын 15 нь парламентын гишүүн Засгийн газрын гишүүний албыг хавсрахыг шаарддаг болон зөвшөөрдөг байхад, 19 нь хориглодог, 4 нь тодорхой квот тогтоож өгсөн байна. Парламентын гишүүн Засгийн газрын гишүүн байхыг шаарддаг эсхүл зөвшөөрдөг 15 улсын хувьд 7 нь хоёр танхимтай, 8 нь нэг танхимтай, 13 нь 120-оос 736 парламентын гишүүнтэй, 2 нь 120-оос доош гишүүнтэй байна. Өөрөөр хэлбэл, парламентын гишүүн Засгийн газрын гишүүн байхыг шаарддаг болон зөвшөөрдөг улсууд нь нэг танхимтай, 120-оос дээш парламентын гишүүнтэй байгаа бөгөөд үүний шалтгаан нь парламентыг “тамга дарагч” төдий болохоос сэргийлдэг. Харин Мальт (65 гишүүнтэй) болон Исланд (63 гишүүнтэй) улсын хувьд парламентын гишүүний тоо нь 120-оос бага боловч парламентын гишүүн Засгийн газрын

гишүүний албыг хавсран гүйцэтгэхийг зөвшөөрдөг. Эдгээр хоёр улс нь парламентын цөөнхийн оролцоог маш сайн хангаж, баталгаажуулж өгсөн байдаг тул ийнхүү зөвшөөрдөг байна.

Парламентын гишүүн Засгийн газрын гишүүний албыг хавсрахыг хориглодог 19 улсын хувьд дийлэнх нь буюу 14 нь нэг танхимтай, 5 нь хоёр танхимтай, 10 нь 151-ээс доош, 9 нь 169-өөс дээш парламентын гишүүнтэй байна. Парламентын гишүүн Засгийн газрын гишүүний албыг хавсрахад тодорхой квот тогтоодог 4 улс байна. Уг 4 улс болох Вануату, Белиз, Энэтхэг, Монгол нь парламентын гишүүний албыг хавсарч буй сайд нар парламентад хэт нөлөөтэй болохоос сэргийлж тэдгээрийн парламентад эзлэх хувийг өөр өөрийн онцлогтойгоор тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, парламентын нэг танхимтай, гишүүдийн тоо цөөн улсын хувьд парламентын гишүүн сайдын албыг хавсран гүйцэтгэхийг хориглох, эсхүл хязгаарлах хандлагатай харин парламентын хоёр танхимтай, гишүүдийн тоо олон тохиолдолд зөвшөөрөх эсхүл шаардах хандлагатай байна. Гэхдээ нэг танхимтай, парламентын гишүүдийн тоо цөөн зарим улсын хувьд (Мальт, Исланд) парламентын гишүүн Засгийн газрын сайдын албыг хавсран гүйцэтгэхийг зөвшөөрч өгсөн байх боловч зөвшөөрснөөр жижиг парламенттай улсад гарах сөрөг үр дагавар (тухайлбал, парламентын хяналт буурах гэх мэт)-ыг “өөр арга хэмжээ, тогтолцоогоор” нөхөж өгдөг. Тухайлбал, Мальт болон Исландын хувьд парламент дахь сөрөг хүчний хяналтыг сайтар баталгаажуулж өгсөн....

3.Монгол Улстай адилхан Ерөнхий сайд-Ерөнхийлөгчийн тогтолцоотой улсууд бараг бүгдээрээ сайд парламентын гишүүн байхыг хориглох эсхүл хязгаарлах хандлагатай байна. Мөн нэг танхимт парламенттай болон парламентын гишүүдийн тоо нь цөөн байгаа улсуудад парламентын гишүүн сайд байхыг хориглох эсхүл хязгаарлах хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хувьд парламентын гишүүний дөрвөөс илүүгүй нь сайд байж болно гэж заасан нь нэг танхимтай, 76 гишүүнтэй, Ерөнхий сайд-Ерөнхийлөгчийн тогтолцоотой улсын хувьд “байж болохуйц” хамгийн үндэслэл бүхий арга замын нэг мөн гэж үзэж байна. “Дөрвөөс илүүгүй” гэсэн квот тогтоосон нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хамтын ажиллагааг дэмжиж илүү үр нөлөөтэй болгох бөгөөд мөн хоёр эрх мэдэл хоорондын “хэт уусал”-аас сэргийлэх, хяналт тэнцвэрийг тогтворжуулахад үр нөлөөтэй сонголт байна.” гэжээ.

Тав. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар ирүүлсэн иргэдийн өргөдөл, мэдээлэл, гомдлыг Үндсэн хуулийн



цэц хянан шийдвэрлэж гаргасан өмнөх шийдвэрүүд нь агуулга, зарчмын хувьд хоорондоо зөрчилтэй байна. Тодруулбал, Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг 2000 онд Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцээд 03 дугаар дүгнэлт, 02 дугаар тогтоол гарган Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж шийдвэрлэж байсан бол 2006 оны 3/06, 2015 оны 17 дугаар магадлалаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцэхгүй гэж шийдвэрлэжээ.

Харин Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн талаар гаргасан иргэдийн өргөдөл, гомдлыг Үндсэн хуулийн цэц урьдчилан шалгахдаа агуулгаар нь хянан үзэж 2020 оны 16, 22 дугаар магадлал гарган маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц холбогдох маргааныг хянан шийдвэрлээд Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаал, үүргийг хавсран гүйцэтгэх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг(тухайн үеийн агуулгын хүрээнд)-ийг зөрчсөн хэмээн шийдвэрлэж 1996 онд 06 дугаар дүгнэлт, 03 дугаар тогтоол, 1998 онд 09 дүгээр дүгнэлт, 02 дугаар тогтоол тус тус гаргасан байна.

Үндсэн хуулийн цэцийн холбогдох шийдвэр гарсны дараа буюу 2010 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг баталж, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцсэн байх шаардлагыг тавьж, нарийвчилсан журмыг хуульчилжээ. Мөн Монгол Улсын Үндсэн хуульд 2000, 2019 онд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасан. Уг зохицуулалтын агуулгаас үзэхэд Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болохын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Удиртгалд тодорхойлсон эрхэм зорилгын хүрээнд, Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл

баримтлалыг хамгаалан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд нийцэж буй эсэхийг хянах чиг үүргийг хэрэгжүүлэхээр байна.

2.Монгол Улсын Үндсэн хуульд үүнээс өмнө оруулж байсан нэмэлт, өөрчлөлтийг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн өмнөх шийдвэрүүд нь агуулга, зарчмын хувьд хоорондоо зөрчилтэй байна.

3.Хууль тогтоогчоос баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь тухайн Үндсэн хуулийн эх бичвэр, үнэт зүйл, эрхэм зорилгыг удирдлага болгосноор Үндсэн хуулийн дотоод нийцлийг алдагдуулахгүй байх, Үндсэн хуулийн зүйл, заалтууд өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх, ард түмний хүсэл зоригийг эрхэмлэн хамгаалж, үндэсний эрх зүйн тогтолцооны нэгдмэл цогц байдлыг хангах боломжийг бүрдүүлнэ. Уг үзэл санаа нь орчин үеийн Үндсэн хуулийн эрх зүйн Үндсэн бүтцийн онолын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг чиг хандлага болно. Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцсэн Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2010 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг баталж, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцсэн байх шаардлагыг хуульчилжээ.

Иймд маргааныг дахин хянан шийдвэрлэх хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцэхгүй гэж шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 3/06, 2015 оны 17 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгон эрх зүйн тодорхой байдлыг бий болгох нь зүйтэй байна.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэж заасны дагуу Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа нь Ерөнхий сайдын бүрэн эрх эхэлж, дуусгавар болохтой шууд хамааралтай байх, Ерөнхий сайд Засгийн газрыг бие даан бүрдүүлэх, Засгийн газрын шийдвэрт Ерөнхий сайд болон тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн

биелэлтийг хариуцахаа илэрхийлж гарын үсэг зурах зэрэг зохицуулалтыг хуульчилж, Засгийн газар танхимын зарчмаар үйл ажиллагаагаа явуулах суурь үзэл баримтлалыг тусгажээ. Үүнийг Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 09 дүгээр тогтоолоор хүлээн зөвшөөрсөн байдаг.

Дээрх суурь үзэл баримтлалыг Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, агуулгын хүрээнд нийцүүлэн баталгаажуулан бэхжүүлжээ.

5.Хууль дээдлэх зарчмын суурь болох Үндсэн хуулийг дээдлэх үзэл баримтлал нь дэлхий нийтийн түгээмэл, эрхэм дээд үзэл санаа болон хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Гуравдугаар зүйлийн 10 дахь заалтаар Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулахдаа "... Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно." гэж заасан нь ард түмний сонгосон парламентын тогтолцоог сулруулах, улмаар засаглалын тодорхойгүй байдалд хүргэх эрсдэлийг бий болгон Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд харшилж, Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино." гэсэн заалтад тус тус нийцээгүй байна.

6.Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн Гучин есдүгээр зүйл болон Дөчин гуравдугаар зүйлд гүйцэтгэх эрх мэдлийн суурь үзэл баримтлалыг бэхжүүлэх хүрээнд холбогдох өөрчлөлтийг хийсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. ..." гэж заажээ. Харин тус зүйлийн 1 дэх хэсэгт Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүн байж болохоор хязгаарласан нь Ерөнхий сайдын эрх мэдэлд халдаж түүний эрх хэмжээг хязгаарлаж, гүйцэтгэх эрх мэдлийн чадамжийг бууруулж, дээрх нэмэлт, өөрчлөлтийн үндсэн үзэл санаа, агуулгатай зөрчилдсөн байна.

7.Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хуулийг эцэслэн батлах босгыг өндөрсгөж, Монгол Улсын Үндсэн

хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй." гэсэн зохицуулалтыг хөндөөгүй атлаа Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг "... Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно." гэж өөрчлөн найруулж, тооны хязгаарлалт тогтоосон нь парламентын гишүүний чөлөөт мандатын агуулгыг үгүйсгэж, хяналт-тэнцлийн зарчмыг алдагдуулахуйц Үндсэн хуулийн дотоод зөрчил үүсгэсэн байна.

8.Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын дагуу парламентын засаглалыг төгөлдөршүүлэх зорилгоор хүн амын тоонд үндэслэн парламентын гишүүдийн тоог нэмж өөрчлөх, сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох замаар хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн тэнцвэр болон төлөөллийн чадварыг бүрэн хангах асуудлыг шийдвэрлэдэг хандлага парламентын засаглал бүхий улс орнуудад нэгэнт тогтсон байна.

Иймд дэлхий нийтийн нийтлэг чиг хандлага, Үндсэн хуулиар баталгаажсан дээрх үзэл баримтлалын хүрээнд Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцүүлэн Улсын Их Хурлын гишүүний тоог нэмэх нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарах асуудал болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1.Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно." гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Удиртгал, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Улсын Их

Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэсэнтэй нийцэхгүй байх тул хүчингүй болгосугай.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 3/06 дугаар магадлал, мөн 2015 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 17 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгосугай.

3.Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЧИНБАТ

ГИШҮҮД

**Д.ОДБАЯР
Ш.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ
Ц.НАНЗАДДОРЖ
Г.БАЯСГАЛАН
Ж.ЭРДЭНЭБУЛГАН
Д.ГАНГАБААТАР**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3.75

Индекс: 200003